МАНАЙ СОНИНЫ II УЛИРЛЫН ЗАХИАЛГА ЯВАГДАЖ БАЙНА

MMINFO.

19 дэх жилдээ

# МОНГОЛЫН МЭДЭЭ

Хүн ам 3,133.596... ҮСХ-ны өчигдрийн мэдээгээр

2017.03.22. Лхагва. №053 (4667) ӨДӨР ТУТМЫН АНХНЫ ЧӨЛӨӨТ ХЭВЛЭЛ Худалдах үнэ 500 төг

Улаанбаатарт: ӨНӨӨДӨР




УЛС ТӨР

С.БЯМБАЦОГТ: ТӨРИЙН ТҮШИГ, ТҮМНИЙ ӨМӨГ БОЛСОН ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН АЖИЛТНУУДДАА АЗ ХИЙМОРИЙГ ЕРӨӨЕ

II нүүрт

ДЭЛХИЙ

ФРАНЦЫН СОНГУУЛЬД НЭР ДЭВШИГЧИД ХАЛЗ МЭТГЭЛЦЛЭЭ

IV нүүрт

Дугаарын 60 мөр

## Иргэд ээ, газар хөдлөлтөд бэлэн үү

Б.СУМЪЯА

Маргааш "Газар хөдлөлтийн аюулаас урьдчилан сэргийлэх, танилцах өдөр"-ийг тэмдэглэн өнгөрүүлэх бөгөөд 16:00 цагт улс орон даяар гамшгийн дуут дохио дуугарч, зарлан мэдээллийн дадлага сургуулилт зохион байгуулна. Жил бүрийн л энэ үед гамшгийн дохио дуугардаг хэдий ч, зарим иргэд юу болж байгааг төдийлөн ойлгохгүй өнгөрөөх нь бий.

Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж өнгөрсөн оны арваннэгдүгээр сард ойрын хугацаанд Улаанбаатар хотод хүчтэй газар хөдлөлт болох магадлал өндөр байгааг анхааруулсан. Тэрбээр үүнээс нэг жилийн өмнө ч гэсэн иим мэдэгдэл хийж байв. Хэвлэл мэдээллийн салбарынхан ч тус бүртээ анхааруулга, сэрэмжлүүлэг, зөвлөгөөг иргэд хүргэж ажилласан билээ.

Үргэлжлэл нь III нүүрт

ДУГААРЫН СУРВАЛЖЛАГА

# ГАЗАР ХАЙСАН ИРГЭД АМИАРАА "ДЭНЧИН" ТАВЬЖ БАЙНА



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

Үргэлжлэл нь VI-VII нүүрт

МОНГОЛ ДЭЛХИЙН ХЭВЛЭЛД

## ОУВС: Монголын татварын хувь хэмжээ бага байна




Б.СУМЪЯА

*Монголын эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдал хэтийн төлөвийг дэлхийн томоохон хэвлэлүүд хэрхэн мэдээлж буйг "Монгол дэлхийн хэвлэлд" буланграаа орчуулан хүргэж байна.*

financialtribune.com: Монгол дахь татварын хэмжээ бага байна

"Монгол Улс дахь татварын хэмжээ бусад хөгжиж буй орныхтой харьцуулахад бага байна. Зарим нь бүр оффшор бүс дэд татварын хувь хэмжээтэй тэнцэхээр тийм бага байна. Хүн хүний орлогын албан татварын хэмжээ гэхэд Ойрхи Дорнодын орнуудтай ижил 10 хувь байгаа юм" хэмээн Олон улсын валютын сангийн Монгол дахь Суурин төлөөлөгч Нейл Сэйкер хэлжээ.

Түүний хэлсэн энэ үг Монгол Улсын Засгийн газар ОУВС-ын 440 сая ам.долларын зээлийн шаардлагыг биелүүлэн зурган төрлийн татвар, нийгмийн даатгалын хувь хэмжээг нэмэгдүүлэх нь эсрэгээр хувийн хэвшилд дарамт үүсгэж, эдийн засгийн бүр ч хүндрүүлэх юм биш үү гэх ганц асуултын хариулт боллоо хэмээн орон нутгийн хэвлэлд мэдээлсэн байна.

Үргэлжлэл нь III нүүрт

# МЭНДЧИЛГЭЭ

*Тэнгэр заяат хөх Монголынхоо нийт ард түмэндээ "Дэлхийн усны өдөр"-ийн амар мэндийг айлтган дэвшүүлье!*

Төв азийн цээжинд эх газрын эрс тэс уур амьсгалтай, хур тунадас бага, усны нөөцөөр хязгаарлагдмал бүсэд оршиж, байгаа нөөц нь нутаг дэвсгэртээ туйлын жигд бус тархсан Монгол орны хувьд амьдралын эх булаг болсон ус нь хамгийн үнэт баялаг юм.



Усны нөөцийг хамгаалах, зүй зохистой ашиглах нь хүн төрөлхтний амьдрах, улс орон оршин тогтнох үндэс нь билээ.

Ийм ч учраас бидний өвөг дээдэс өнө эртнээс усыг амьдралын эх үндэс хэмээн дээдэлж, усаа бохирдуулахгүй, ариун тунгалаг байлгахыг эгнэгт эрхэмлэж, усны эх булгийг онцгойлон хамгаалж ирсэн сайхан уламжлалтай. Өвөг дээдсийнхээ мөрдөж ирсэн энэ сайхан ёс заншил, уламжлалаа өнөөгийн нөхцөлд баяжуулан хөгжүүлж, бодлоого болгон хэрэгжүүлэх нь өнөөдөр иргэн бүрийн журамт үүрэг юм.

2017 оны Дэлхийн усны өдрийн уриаг НҮБ-аас "Хаягдал ус" хэмээн зарласан бөгөөд бидний хувьд энэ өдрийг "Хаягдал ус-нөөц баялаг" уриан дор тэмдэглэн өнгөрүүлж байна.

Монгол орны усны нийт нөөцийг сүүлийн 40 жилийн судалгаанаас үзвэл жил тутам дунджаар 564.8 км3 байдаг ба үүний 82.5 хувь буюу 500 км3 -г нуур, 6.1 хувь буюу 34.6 км3 -ийг гол, мөрөн, 3.4 хувь буюу 19.4 км3 -ийг мөнх цас, мөсөн гол, 1.9 хувь буюу 10,8 км3 -ийг газрын доорх ус тус тус эзэлж байна. Гэтэл бид өнөөдөр хүн ам, нийгэм-эдийн засгийн салбаруудын усны хэрэглээний 80 гаруй хувийг Монгол улсын нийт усны нөөцийн 1.9 хувийг эзэлж байгаа газрын доорх усаар, 20 хүрэхгүй хувийг гадаргын усаар хангаж байна. НҮБ-аас Дэлхийн усны өдрийг "хаягдал ус" гэж нэрлэсэн нь тохиолдлын хэрэг биш юм. Хаягдал ус нь өөрөө дахин ашиглагдах боломж бүхий "нөөц баялаг" бөгөөд бид хаягдал усыг цэвэрлэж, эргүүлэн ашиглах шинэ дэвшилтэт техник технологийг эрчимтэй нэвтрүүлэхэд онцгой анхаарч, өндөр ач холбогдол өгч хэрэгжүүлэх цаг нь болсон.

Монгол улсын Засгийн газрын зүгээс усны салбарт томоохон ажлуудыг хийж, хэрэгжүүлж эхлээд байгаагаас энд дурдахад таатай байна. Тухайлбал "хаягдал ус"-ыг нь эргүүлэн ашиглах боломжтой байдлаар Улаанбаатар хотын Төв цэвэрлэх байгууламжийг шинэчлэх ажлыг энэ ондоо багтаан эхлүүлэхээр гэрээ, хэлэлцээрийн түвшинд ажиллаж байна. Мөн хаягдал усыг эргүүлэн ашиглах хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгохоор Ус бохирдуулсны төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг УИХ-ын хаврын чуулганд өргөн барина.

Ирээдүй хойч үедээ энэ сайхан Монгол орноо цэвэр цэнгэг устай нь, онгон сайхан байгальтай нь үлдээхийн төлөө ухаант хүн бүр өөрсдөөс шалтгаалах бүхнийг чин сэтгэлээсээ хийж, өдөр тутмын хэрэглээндээ чандмань эрдэнэ болсон усыг хэмнэх, ариг гамтай ашиглах ахуйн соёл, дадал заншлыг улс үндэстнийхээ үнэт зүйл болгон төлөвшүүлэхийг Та бүхэндээ уриалж байна.

Амь амьдралын эх булаг, чандмань эрдэнэ болсон усаа хайрлан хамгаалж, зүй зохистой ашиглахад хүч, хөдөлмөрөө зориулж ирсэн Усны салбарын үе үеийн эрдэмтэн судлаачид, алба хаагчдад "Дэлхийн усны өдөр"-ийг тохиолдуулан Байгаль орчин, аялал жуулчлалын яамны нэрийн өмнөөс аз жаргалтай, амар амгалан амьдралын гэгээн ерөөлийг өргөн дэвшүүлье.

Аливаа бүхний эхлэл болсон, Амьдрал жаргалын эрдэнэ болсон, Ус гэдэг үнэн гайхамшигт "чандмань эрдэнэ"-ийн төлөөх Та бидний хамтын ажиллагаа дуусаж, дундаршгүй оргилуун их амжилтыг хүсэн ерөөе.

ХҮНДЭТГЭСЭН,

**Улсын Их Хурлын гишүүн, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд** **Д.ОЮУНХОРОЛ**

# "БАГАНУУР" ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

"Багануур" ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2017 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн 11.00 цагт Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 13-р хороолол, Манлайбаатар Дамдинсүрэнгийн гудамж 23-1 байрлах Багануур-Илч ХХК-ийн 2 давхарт 103 тоот хурлын танхимд хуралдаж дараах асуудлыг хэлэлцэнэ. Үүнд:

1. Багануур ХК-ийн 2016 оны үйл ажиллагааны тайлан
2. Компанийн аудитлагдсан санхүүгийн тайлан, Аудитын хорооны дүгнэлт
3. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2016 оны үйл ажиллагааны тайлан болон 2017 оны зардлын төсвийг батлах тухай
4. Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох
5. Ногдол ашгийн тухай

Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2017 оны 04 дүгээр сарын 03-ны өдөр, хувьцаа эзэмшигчдийн саналын хуудсыг хүлээн авах эцсийн өдрийг 04-р сарын 27-ны өдрийн 17.00 цагаар тасалбар болгоно.

Хувьцаа эзэмшигч та бүхэн хурлын холбогдох материалтай 2017 оны 04-р сарын 07-ны өдрөөс эхлэн "Багануур-Илч" ХХК, харьяа брокер, дилерийн компани дээрээ ирж танилцан хуралдаа идэвхитэй оролцоно уу.

**ХУРАЛ ХУРАЛДАХ ГАЗРЫН ХАЯГ:**

"Багануур" ХК-ийн охин компани Багануур-Илч ХХК-ийн 2 давхарт 103 тоот хурлын танхимд, /Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 13-р хороолол, Манлайбаатар Дамдинсүрэнгийн гудамж 23-1/.

**ЛАВЛАХ УТАС:**

"Багануур Илч" ХХК, Утас 70157719

Хурал зохион байгуулах комисс: 99815690, 99172076

**ХААН банк**

| | Авах | Зарах | | Авах | Зарах |
|---|---|---|---|---|---|
| АМ.ДОЛЛАР | 2450.00 | 2464.00 | ФУНТ | 2993.00 | 3087.00 |
| ЕВРО | 2607.00 | 2680.00 | РУБЛЬ | 41.90 | 43.80 |
| ИЕН | 21.72 | 22.03 | ЮАНЬ | 355.00 | 357.90 |

**Худалдаа хөгжлийн банк**

| | Авах | Зарах | | Авах | Зарах |
|---|---|---|---|---|---|
| АМ.ДОЛЛАР | 2454.00 | 2468.00 | ФУНТ | 3006.00 | 3080.00 |
| ЕВРО | 2613.00 | 2679.00 | РУБЛЬ | 41.73 | 44.82 |
| ИЕН | 21.60 | 22.17 | ЮАНЬ | 355.00 | 358.90 |

*Өчигдрийн 19.00 цагийн байдлаар*

E-mail: mongoliin_medee@yahoo.com

Реклам, зар сурталчилгааны алба: 99173710

# УЛС ТӨР

МЭДЭЭЛЭЛ

## У.Хүрэлсүх ОХУ-ын Ерөнхийлөгчийн ХЭГ-ын орлогч даргатай уулзав

Монгол Улсын Шадар сайд, Монгол, Оросын Засгийн газар хоорондын комиссын Монголын хэсгийн дарга У.Хүрэлсүх ОХУ-ын Ерөнхийлөгчийн Хэрэг эрхлэх газрын орлогч дарга Павел Михайлович Фрадковтай өчигдөр уулзав. Уулзалтын үеэр хоёр орны найрсаг харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэх асуудлаар санал солилцож, өнгөрсөн оны арванхоёрдугаар сард Улаанбаатар хотноо зохион байгуулсан Монгол, Оросын Засгийн газар хоорондын комиссын 20 дугаар хуралдаанаар тохирсон арга хэмжээнүүдийг бүрэн хэрэгжүүлж ажиллах нь чухал болохыг тэмдэглэв. Саяхан Гадаад хэргийн сайд Ц.Мөнх-Оргил ОХУ-д айлчилсан, удахгүй Монгол Улсын Ерөнхий сайд ОХУ-д айлчлахаар төлөвлөж буй нь хоёр орны найрамдалт харилцаа, хамтын ажиллагааг урагшлуулахад чухал түлхэц болох тул уг айлчлалыг үр бүтээлтэй хэрэгжүүлэх асуудлыг уулзалтын үеэр хөндөн ярилцлаа. Түүнчлэн уулзалтын үеэр Монгол Улс дахь ОХУ-ын үл хөдлөх хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх талаар хоёр талын хийж буй ажлыг наштайгаар үнэлж, цаашид маргаантай асуудлыг үе шаттайгаар Монгол Улсын хууль, тогтоомж болон хоёр талын холбогдох хэлэлцээрийн хүрээнд шийдвэрлэнэ гэж үзэж буйгаа оросын тал илэрхийлсэн юм.

MMINFO.

МОНГОЛЫН МЭДЭЭ

19 дэх жилдээ

Ерөнхий эрхлэгч:
С.ГАНТОГОО

Орлогч эрхлэгч
Ч.ЧУЛУУНЦЭЦЭГ
99189158

Хариуцлагатай нарийн бичгийн дарга:
Э.ЭНХЦЭЦЭГ
90873012

Ахлах редактор:
Б.ӨНӨРТОГТОХ
88006842

Шуурхай мэдээлэл, эрэн сурвалжлах алба
Н.ПУНЦАГБОЛД
88096454

Улс төр, гадаад мэдээлэл, эдийн засгийн алба:
Б.ӨНӨРТОГТОХ
88006842

Гэрэл зургийн алба:
Г.АРГУУЖИН
96017873

Компьютерийн алба:
Б.ГАНЗОРИГ
99998796

Маркетинг, зар сурталчилгааны алба:
Н.АЛТАНЦЭЦЭГ
99173710

Захиалга, борлуулалтын алба:
М.ДАВААДУЛАМ
99042510

Э.САЙНЗАЯА
99197866

Дугаарыг эрхэлсэн
Э.ЭНХЦЭЦЭГ

Улсын бүртгэлийн дугаар: 907300528
Индекс: 100757

Редакцийн хаяг:
Улаанбаатар хот. Сүхбаатар дүүрэг. Чөлөөт хэвлэл сан /Хэвлэлийн хүрээлэн/. 2 давхар. 209, 211 тоот

Харилцах утас, факс:
976-70113551

"Монголын мэдээ" сонины редакцид эхийг бэлтгэж, "Чөлөөт хэвлэл сан"-ийн хэвлэх үйлдвэрт хэвлэв.

ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ

## С.БЯМБАЦОГТ: ТӨРИЙН ТҮШИГ, ТҮМНИЙ ӨМӨГ БОЛСОН ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН АЖИЛТНУУДДАА АЗ ХИЙМОРИЙГ ЕРӨӨЕ

Ж.ОТГОН

Цагдаагийн албаны тухай хуулийн эх бичвэрийг хүлээн авах үйл ажиллагаа өчигдөр Сүхбаатарын талбайд боллоо. Хууль тогтоомжийн тухай хуулийг хэрэгжүүлэх хүрээнд шинээр батлагдан гарч буй хуулийн эхийг хуульхэрэгжүүлэгчидньгардуулан өгч, олон нийтийн хүртээл болгох, нэг мөр хэрэгжүүлэх ажлыг эхлүүлдэг сайн жишиг тогтож байгаа юм. Хуулийн эх гардуулах арга хэмжээнд Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат, УИХ-ын дарга М.Энхболд, Дэд дарга Ц.Нямдорж, ХЗДХ-ийн сайд С.Бямбацогт, ЗГХЭГ-ын дарга Ж.Мөнхбат, ЦЕГ-ын дарга Ө.Энхтөр нар оролцов. Мөн УИХ-ын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн дарга Ц.Цолмон, ХЗДХ-ийн дэд сайд Б.Энхбаяр, ХЗДХ-ийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Баясгалан, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч С.Батболд, Цагдаагийн ерөнхий газрын даргаар ажиллаж байсан хошууч генерал Б.Пүрэв, Д.Сандаг-Очир, С.Дамдинсүрэн, Ч.Амарболд нар болон бусад байгууллагын төлөөлөл урилгаар оролцлоо.

Ёслолын ажиллагааг Цагдаагийн ерөнхий газрын дарга, цагдаагийн хурандаа Ө.Энхтөр нээж үг хэлэв. Тэрбээр хэлэхдээ, 1993 онд Цагдаагийн байгууллагын тухай анхны хууль батлагдаж, байгууллагын чиг үүрэг, тогтолцоо, алба хаагчдын эрх зүйн байдлыг хуульчилж өгснөөр түүхэн үүргээ бодитойгоор хэрэгжүүлж чадсаныг тэмдэглээд "Өнөөдөр бидэнд гардуулан өгч байгаа Цагдаагийн албаны тухай шинэчлэн найруулсан хууль нь ард иргэдээсээ тавих хяналтыг нэмэгдүүлж, гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэхэд олон нийт, цагдаагийн албаны ажиллагааг ойртуулан цагдаагийн байгууллагын үйл ажиллагааг шуурхай, шийдвэр гаргах эрхийг тодорхой болгож, алба хаагчдын нийгэм, эрх зүйн баталгааг хангаж өгснөөрөө онцлог юм" гэлээ.

Үүний дараа УИХ-ын дарга М.Энхболд үг хэлж, цагдаагийн албаны нийт бие бүрэлдэхүүнд





Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

мэндчилгээ дэвшүүллээ. Улмаар Цагдаагийн албаны тухай хуулийн эх бичвэрийг Засгийн газрын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайд С.Бямбацогтод гардуулсан. УИХ-ын дарга М.Энхболд "Сүүлийн жилүүдэд Цагдаагийн албаны тухай хууль болон түүнийг дагалдаж гарсан эрх зүйн актууд хэрэгжиж, цагдаагийн албаны бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааны эрх зүйн орчинд нэлээдгүй өөрчлөлт орсныг бүхэлд нь дүгнэж хэлбэл томоохон шилжилтийн үйл явц болсон билээ. Энэхүү шилжилтийн хүрээнд эерэг өөрчлөлт гарсан ч цаашид боловсронгуй болгон шийдвэрлэх асуудлууд цөөнгүй байсан юм. Тиймээс шинэ Засгийн газар Цагдаагийн албаны тухай хууль болон холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг өргөн барьж, Улсын Их Хурал 2016 оны намрын ээлжит чуулганаараа хэлэлцэн баталсан юм. Өнөөдөр энэ хуулийг хүлээлгэн өгч, хэрэгжүүлж эхлэх ёслолын арга хэмжээ болж байна. Шинэ хуульд цагдаагийн алба нь гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах гэсэн гурван үндсэн чиг үүрэгтэй байхаар тусгаж, цагдаагийн алба хаагчийн үйл ажиллагааг хуулиар баталгаажуулж өглөө. Мөн цагдаагийн байгууллагын бүтэц, зохион байгуулалт нь Цагдаагийн төв байгууллага, түүний харьяа алба, орон нутаг дэвсгэрт цагдаагийн байгууллагын нэгж бүрэлдэхүүнээс бүрдсэн байхаар тогтсон. Цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны стандартыг дээшлүүлэх, үйл ажиллагаагаа иргэдийн хэрэгцээ, шаардлагатай уялдуулах үүднээс цагдаагийн алба хаагч үүргээ гүйцэтгэх үедээ иргэнд хүндэтгэлтэй хандаж, иргэд олон нийтийн дэмжлэгийг авах, итгэлийг хүлээхийг эрмэлзэх үүргийг энэ хуулиар хуульчилж өглөө" хэмээсэн юм.

Цагдаагийн алба хаагчид цагдаагийн дээд, дунд, бага цол олгохоор тусгаж, тэтгэвэр тогтоолгох насыг цолны байдлаас хамааруулан ялгавартай байхаар хуульд заасан. Цаагдаагийн албаны тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулиар Тахарын албыг татан буулгасантай холбогдуулан уг байгууллагын хэрэгжүүлж байсан зарим чиг үүргийг цагдаагийн байгууллагад шилжүүлж, ажиллаж байсан алба хаагчдын цол, ажилласан жилийг цагдаагийн албанд ажиллаж байснаар тооцохоор, мөн 2013 онд батлагдсан Цагдаагийн албаны тухай хуулийн дагуу тогтоосон "албан тушаалын цол"-ны нэршлийг өөрчилж, албан тушаал, алба хаасан хугацаа, ажлын үр дүнг харгалзан цагдаагийн цол олгодог байхаар шинэ хуульд зохицуууллаа гэдгийг тэрбээр онцолж байлаа. Харин Цагдаагийн албаны тухай хуулийн эх бичвэрийг гардан авсан ХЗДХ-ийн сайд С.Бямбацогт хэлсэн үгэндээ "Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажсан иргэний үндсэн эрхийг хамгаалах хууль зүйн боломжийг улам нэмэгдүүлэх, олон нийтийн аюулгүй байдлыг хангах зорилгыг хэрэгжүүлэхэд Цагдаагийн албаны тухай хууль нэн тэргүүнээ үйлчлэх болно. Ингэснээр манай оронд эрх зүйт төрийг улам бүр төлөвшүүлэн хөгжүүлэх үйлсэд томоохон алхам болно гэдэгт итгэлтэй байна. Монгол түмэн ардын цагдаадаа итгэж, Монгол Улс төрийн цагдаагаа дэмжин түшиж ирсэн ариун уламжлал цагийн эрхэнд алдрах учиргүй. Төрийн түшиг, түмний өмөг болсон цагдаагийн байгууллагынхаа нийт бие бүрэлдэхүүнд аз хийморь, цог залийг эрхэмлэн ерөөе" хэмээгээд Цагдаагийн албаны тухай хуулийн эх бичвэрийг ЦЕГ-ын дарга, цагдаагийн хурандаа Ө.Энхтөрд гардуулсан юм. Үүний дараа цагдаагийн алба хаагчид шинээр тангараг өргөх ёслолын ажиллагаа боллоо. Тангараг өргөх ёслолын ажиллагаанд Эрүүгийн цагдаагийн алба, Мөрдөн байцаах алба, Замын цагдаагийн газар, Хууль сахиулахын их сургууль, Тусгай ажиллагааны газар болон Нийслэлийн цагдаагийн газар, нийслэлийн Баянгол дүүрэг дэх цагдаагийн нэг, хоёрдугаар хэлтэс зэрэг Улаанбаатар цагдаагийн хүрээний алба хаагчид оролцсон юм.

Ёслолын төгсгөлд Тугийн салааны бүрэлдэхүүн жанжин Д.Сүхбаатарын талбайгаас Цагдаагийн албаны байлдааны туг, Цагдаагийн албаны тухай хуулийн эх бичвэрийг Цагдаагийн ерөнхий газрын Ёслол, хүндэтгэлийн танхимд заллаа.

МЭДЭЭ, МЭДЭЭЛЭЛ

## Жан Тодт: Гурван сая хүн амтай улсын хувьд осол аваарын тоо өндөр байна

Зам, тээврийн хөгжлийн сайд Д.Ганбат НҮБ-ын Замын хөдөлгөөний аюулгүй байдлын Тусгай элч Жан Тодтыг хүлээн авч уулзлаа. Тэд Монгол Улсын замын хөдөлгөөний аюулгүй байдлын асуудлууд болон хамтын ажиллагааны асуудлуудаар санал солилцсон байна. Тусгай элч Жан Тодт ажил амьдралынхаа гарааг уралдааны машины туслах жолоочоор эхэлж энэ хугацаанаас хойш өөрийн амьдралыг автомашинтай холбожээ. Монгол Улсад авто-мото спорт хөгжиж байгаа боловч дэд бүтэц сул хөгжсөн тул хурдны замын төрлийн автомашины уралдаан төдийлөн хөгжөөгүй. Гэхдээ өргөн уудам газар нутагтай тул дотооддоо бартаат замын төрлийн уралдаан болон ралли төрлийн холын зайн уралдаануудыг зохион байгуулдаг ба цаашид олон улсын хэмжээнд ийм төрлийн тэмцээн зохион байгуулах бүрэн боломжтойг талаар уулзалтын эхэнд Зам, тээврийн хөгжлийн сайд Д.Ганбат онцоллоо. Харин Тусгай элч Жан Тодт "Тоо баримтаас харахад осол зөрчил, нас баралтын үзүүлэлт өмнөх онуудын үзүүлэлтээс буурч байгаа хэдий ч гурван сая хүн амтай Монгол Улсын хувьд сэтгэл түгшээсэн өндөр тоо харагдаж байна. Тиймээс энэ асуудалд Засгийн газрын түвшинд томоохон зорилт дэвшүүлж, шат дараатай арга хэмжээ авах нь зүйтэй. Ялангуяа иргэд, зорчигчдод чиглэсэн соён гэгээрүүлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх хэрэгтэй. Боловсролын салбарт тусгай хөтөлбөр бий болгох зэрэг олон арга зам бий. Мөн тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдал, норм стандартыг хангуулж, буруу талдаа хурдтэй тээврийн хэрэгслийн асуудлыг яаралтай шийдьэрлэх шаардлагатай" хэмээн өөрийн судалгаа, туршлагаасаа хуваалцлаа. Мөн тэрээр НҮБ-ын замын хөдөлгөөний аюулгүй байдлын холбогдолтой суурь конвенциудад нэгдэн ороход НҮБ-ын зүгээс дэмжиж, хамтран ажиллана гэдгээ илэрхийллээ.

## УИХ-ын дарга М.Энхболд Японыг зорино

УИХ-ын дарга М.Энхболд энэ сарын 27-ноос Япон улсад албан ёсны айлчлал хийх гэж байна. Энэ удаагийн айлчлал нь УИХ-ын даргын хувиар хийх анхных нь айлчлал болох юм. Айлчлалын тов эцэслэж гараагүй ч тус улсад гурав хоногийн айлчлал хийх аж. Энэ үеэр Монгол, Японы стратегийн түншлэлийн дараагийн дунд хугацааны хөтөлбөрийг эцэслэн тохирох талаар санал солилцох юм байна. Улмаар айлчлалаа өндөрлүүлснийхээ дараа Бангладешийг зорино. Тус улсад ирэх дөрөвдүгээр сарын 02-ныг хүртэл Олон улсын парламентын холбооны хурал болох аж. Түүнд УИХ-ын дарга М.Энхболд оролцох юм байна.

ЗАСГИЙН ГАЗАР

## "АГААРЫН БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР"-ИЙГ БАТАЛЛАА

Ж.МЯГМАР

Засгийн газрын ээлжит хуралдаанаар энгийн гадаад паспортын сунгахгүй тав болон 10 жилээр олгох, "Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр"-ийг батлах, "Гашуун сухайтын төмөр зам" компанийг татан буулгах зэрэг асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэжээ.

### ГАДААД ПАСПОРТЫГ СУНГАХГҮЙ ТАВ БОЛОН 10 ЖИЛЭЭР ОЛГОНО

2004 онд Каир хотноо болсон Олон улсын иргэний нисэхийн байгууллагын 12 дугаар уулзалтаас "Машинаар унших паспортын хүчинтэй хугацааг сунгахгүй байх, дардас, резинэн тамгаар сунгасан паспортыг машинаар уншигдах баримт бичиг гэж хүлээн зөвшөөрөх үндэслэлгүй болох тухай"



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

Протокол гаргасан юм. Үүнтэй холбоотойгоор Монгол Улсын иргэд энгийн гадаад паспортынхаа хугацааг сунгуулж гадаадад зорчих нөхцөлд үүнийг нь дэлхийн олон орон үл хүлээн зөвшөөрөх, олон улсын нислэгээр зорчуулахгүй байх, хилээр нэвтрүүлэхгүй эрсдэл үүсч байгаа юм. Иймд олон улсын стандартад нийцүүлэх зорилгоор Монгол Улсын энгийн гадаад паспортыг чипгүй бол таван жилийн, харин чиптэй энгийн гадаад паспортыг 10 жилийн хугацаатай олгож, дахин сунгалт хийхгүй байхаар тогтов. Засгийн газрын энэхүү тогтоолтой холбоотойгоор иргэдээс авдаг төлбөр хураамжид ямар нэгэн өөрчлөлт орохгүй юм.

### "ГАШУУНСУХАЙТЫН ТӨМӨР ЗАМ" КОМПАНИЙГ ТАТАН БУУЛГАВ

Гашуунсухайт-Ганцмод боомтын нарийн царигийн бүхий боомтын төмөр замд хөрөнгө оруулалт хийж, барих, ашиглах зорилготой байгуулсан "Гашуунсухайтын төмөр зам" ХХК-ийг татан буулгахыг "Эрдэнэс Тавантолгой" ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлд үүрэг болгов. Компанийн зарцуулсан хөрөнгийг хөндлөнгийн аудитаар хянан баталгаажуулж, Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төсөлд оруулах гадаадын хөрөнгө оруулалтаас эргэн төлөх арга хэмжээ авахыг холбогдох сайд, агентлагийн дарга нарт даалгалаа. Засгийн газрын 2016 оны 268 дугаар тогтоолоор "Нарийнсухайт-Шивээхүрэн" чиглэлийн төмөр замын барилгын ажлыг энэ оны эхний хагас жилд багтаан эхлүүлнэ гэж заасан. Иймээс дээрх чиглэлийн 45.3 км, Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн 267 км төмөр замын бүтээн байгуулалтыг нэгдсэн удирдлага, зохион байгуулалт дор цогцоор нь барьж байгуулах нь зүйтэй гэж үзлээ.

### "АГААРЫН БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР"-ИЙГ БАТАЛЛАА

Хөтөлбөрийг 2017-2018 он хүртэл буюу богино хугацааны, 2018-2021 он хүртэл буюу дунд хугацааны гэсэн хоёр үе шаттайгаар хэрэгжүүлэхээр боллоо. 59 арга хэмжээ бүхий хөтөлбөрийг хэрэгжүүлснээр гэр хорооллын айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагуудын ашиглаж байгаа түүхий нүүрсний хэрэглээг бүрмөсөн хориглох юм. Ингэснээр агаар бохирдуулагч эх үүсвэр 80 хувиар багасч, тоосонцор, хүхэрлэг хийг 50-иас доошгүй хувь буурна гэж тооцоолжээ. Хөтөлбөрийн хүрээнд агаарын бохирдлыг бууруулах дэвшилтэт техник, технологийг нийтэд танилцуулах "Байгаль орчинд ээлтэй техник, технологийн мэдээллийн төв"-ийг байгуулна. Мөн Ерөнхий сайдаас өгсөн чиглэлийн дагуу Агаарын бохирдлын эсрэг сан байгуулах тухай хуулийн төслөөс гадна байгаль орчныг хамгаалах, агаар, орчны бохирдлыг бууруулах, нөхөн сэргээлт хийх чиглэлээр үүрэг, хариуцлагыг тодорхой болгох, олон нийтийн хяналт, оролцоог нэмэгдүүлэх зорилгоор холбогдох хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулах юм байна.

# ҮЗЭЛ БОДОЛ

ӨНӨӨДРИЙН ТОП ИШЛЭЛ




Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

МОНГОЛ ДЭЛХИЙН ХЭВЛЭЛД

# ОУВС: МОНГОЛЫН ТАТВАРЫН ХУВЬ ХЭМЖЭЭ БАГА БАЙНА










**Үргэлжлэл. Түрүүч нь I нүүрт**

Монголын Бизнесийн зөвлөл 2017 оны гуравдугаар сарын 13-нд анхны уулзалтын хийсэн бөгөөдтусуулзалтаархэлэлцсэн асуудлын нэг нь ОУВС-ийн өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр Монгол Улсын эдийн засагт хэрхэн нөлөөлөх талаар байсан юм.

Энэ үеэр Монгол банкны дэд Ерөнхийлөгч Б.Лхагвасүрэн өнгөрсөн дөрвөн жилийн хугацаанд өмнөх эрх баригчид найман тэрбум ам.доллар орчим асар их мөнгийг үр ашиггүй зүйлд зарцуулснаас үүдэн өнөөгийн хүндрэл үүссэн хэмээн тэмдэглэж байв. Түүнчлэн, “Бид эдийн засгийн хүнд хэцүү энэ үед Засгийн газар иргэдийнхээ дуу хоолойг сонсохыг зогсолтгүй шаардаж, байр сууриа илэрхийлэх ёстой” гэж эдийн засагч Д.Жаргалсайхан хэллээ.

Монгол Улсын Засгийн газар 2019 он хүртэл цалин нэмэхгүй байх шийдвэр гаргасан. Мэдээж, энэ төрийн албан хаагчдын хувьд сайн мэдээ биш байж таарна. Гэхдээ инфляци харьцангуй бага төвшинд байгаа бөгөөд цаашид ч хэвээр хадгалагдах төлөвтэй байгаа юм. Тиймээс иргэдийн бодит орлого багасах, валютын ханш унах эрсдэл байгаар уулзалтад оролцогсод онцолжээ.

## akipress.com: Ирэх жилүүдэд 40 хүртэл тонн алт экспортлоно

Монгол Улс ирэх арван жилд 16-40 тонн алт экспортлохоор төлөвлөжээ. Энэ талаар гуравдугаар сарын 17-нд Чингис зочид буудалд нээгдсэн “Монгол алт 2017” бага хурлын үеэр мэдэгдсэн байна. Тус үйл ажиллагааг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Монгол банк, Монголын уул уурхайн бирж хамтран зохион байгуулжээ.

Монгол Улсын Засгийн газраас “Алт-2” хөтөлбөрийг эдийн засгийн сэргээх гол арга хэмжээний нэг болгон батлан бөгөөд алтны экспортоо жил бүр 2-3 тонноор ахиулсаар 2020 он гэхэд 25 тонпд хүргэх зорилт тавьж буй аж.

Энэ дагуу ирэх арван жил Монголын алтны экспорт 15.8-40 тонпд хүрч, 2020 он гэхэд алтны экспортоос олох орлого 1.178 тэрбум ам.доллар болох юм.

Бага хурлаар алтны секторуудтай холбоотой асуудлыг өргөн хүрээнд хэлэлцэж, алт олборлолт явуулах эрх зүйн орчныг сайжруулах, тогтворжуулах арга замыг эрэлхийлэхээр төлөвлөжээ. Тус үйл ажиллагаа сүүлийн жилүүдэд тулгараад буй эдийн засгийн асуудлыг шийдвэрлэх гарцыг хайхад чиглэгдэж байв. Үүнтэй холбоотойгоор Засгийн газар олон улсын туршлага судлаж, дэвшилтэт технологи санал болгож буй хөрөнгө оруулагчдад “Алт-2” төслийг танилцуулах, эдийн засаг, хамтын ажиллагааг өргөжүүлэх зэрэг ажлуудыг төлөвлөж байна.

## timesofindia.india–times.com: Монголын эдийн засаг 7–8 хувийн тогтмол өсөлтэд хүрнэ

Монгол Улс эдийн засгийн бэрхшээлүүдээ даван туулснаар 7-8 хувийн тогтмол өсөлттэй болно хэмээн ОУВС-гийн Монгол дахь суурин төлөөлөгч Нейл Сэйкер хэлснээр “Ройтерс” мэдээлжээ. Тэрбээр “Би хөтөлбөр хэрэгжсэний дараах Монголын эдийн засгийн тогтвортой өсөлтийг 7-8 хувь болно гэж харж байна” хэмээн даваа гарагт болсон хэлэлцүүлгийн үеэр хэлсэн байна. Мэдээж байгалийн баялгийн оргил үе буюу 2011 оны 17.3 хувийн өсөлтийг бодвол хамаагүй удаан байх болно гэдгийг тэрбээр нэмж хэлжээ. ОУВС болон бусад түншүүд Монгол Улсад 5.5 тэрбум ам.долларын санхүүжилтийн тусламж олгож, түүхий эдийн экспортын орлого нь буурсан байгаа энэ үед эдийн засгийн тогтвортой байдлыг бий болох багцыг өнгөрсөн хоёрдугаар сард тус улсын Засгийн газартай тохиролцсон юм. Хөтөлбөрт заасчаар дагалдай гарцгүй улсын хувьд Монгол Улсын Засгийн газар зардлаа хэтрүүлэхгүй байхыг санал болгосон юм. Энэхүү тусламжийн багц хөтөлбөр нь хөрөнгө оруулагчдын итгэлийг нэмэгдүүлж, Монгол Улсын төрийн өмчит Хөгжлийн банкны 580 сая ам.долларын бондыг 600 сая ам.долларын шинэ өрийн свопоор амжилттай солихоор тусгасан юм.

Хөгжлийн банкны бонд ээмшигчид 476 сая ам.доллартай тэнцэх бондоо шинэ бондоор солых ахсан бөгөөд шинэ хөрөнгө оруулагчид 124 сая ам.доллартай тэнцэх бондын 2024 он хүртэл хугацаатайгаар худалдаж авсан. Харин үлдсэн 104 сая ам.долларын бондыг энэ гуравдугаар сарын 21-ний өдөр арилжаалах аж. Тэрбээр “Монгол Улс хөрөнгө оруулаг-чидтай амжилттай тохиролцсон. Шинээр гаргасан бонд анх төлөвлөснөөс тав дахин их захиалга авсан” гэжээ.

## Tass.com: Монгол Улсын Ерөнхий сайд ОХУ-д айлчилна

Монгол Улсын Ерөнхий сайд Ж.Эрдэнэбат энэ оны эхний хагаст ОХУ-д айлчилна гэж Москва дахь Монголын Элчин сайд Б.Дэлгэрмаа мэдээллээ.

Элчин сайд Б.Дэлгэрмаа “2016 онд Улаанбаатарт болсон Засгийн газар хоорондын комиссын уулзалтан дээр бид зөвхөн худалдаа, эдийн засгийн салбар гэлтгүй бүх салбарт хамтран ажиллах талаар тохиролцсон. Энэ хүрээнд бид олон жилүүдэд хийх ажлаа төлөвлөсөн. Тиймээс манай Элчин сайдын яам ОХУ-ын яам, агентлагуудтай хамтарч ажиллаж байна” гэлээ.

Мөн “Бид олон жил яригдсан төмөр замын тээвэр, төмөр замын тээвэрлэлтийн үед онцгой албан татвар ногдуулах, ус хадгалах байгууламж барих, хилийн бүс нутгуудын хамтын ажиллагаа зэрэг асуудлуудыг шийдвэрлэх төлөвлөгөөг баталсан. Манай Элчин сайдын яам ОХУ-ын яамд болон агентлагийн бүх төвшинд хамтран ажиллаж байна. Бид Монгол Улсын Ерөнхий сайдыг энэ оны эхний хагаст ОХУ-д айлчлахаас өмнө хоёр орны харилцаанд тулгараад буй асуудлын 40-50 хувийг нь зорицуулж, практик талаас нь шийдвэрлэх болно” хэмээн нэмж хэлсэн байна.

Түүний хэлснээр, Засгийн газрын хоорондын комиссын дараагийн ээлжит хурлыг 2017 оны сүүлээр Москвад зохион байгуулахаар төлөвлөжээ.

ОХУ-ын Ерөнхий сайд Дмитрий Медведев 2016 оны долдугаар сард Монголд айлчилж байсан билээ. Тэрбээр АСЕМ-ын уулзалтад оролцох үеэрээ Монголын төр засгийн тэргүүнүүдтэй хэд хэдэн удаа хоёр талт уулзалт хийсэн юм.

Дугаарын 60 мөр

## Иргэд ээ, газар хөдлөлтөд бэлэн үү

**Үргэлжлэл. Түрүүч нь I нүүрт**

Гэвч “Сүх далайтал үхэр амар” гэгчээр хэзээ л бол хэзээ нүүр тулж мэдэх газар хөдлөлтийн аюулаас сэргийлэх зөвлөмжийг мөрддөг жирийн иргэн бий болов уу. Төрийн байгууллагын ажилтнууд нь онгоцсон үүргэ даалгаврын дагуу гамшгийн дохио дугармагц ширээн доогуураа хэсэг хугацаанд нуугдаг байж болох. Харин үүний дараа бид юу хийх ёстой вэ. Хүчтэй газар хөдлөх үед мэдээлэл солилцож чадахгүй болох, тог, ус тасрах, жорлонгийн ус ашиглах боломжгүй болох, нийтийн тээвэр зогсч, хүнсний гачигдал гэх зэрэг эрсдэлүүд тулгарна. Автобусаар зорчиж явахад, лифтэнд байхад, банкинд дугаарлаж байхад, эсвэл зүгээр л ажлаа хийж явахад тань газар чичирхийлбэл яах вэ. Энэ талын мэдлэг мэдээлэлтэй хүн байгаа эсэх нь тун эргэлзээтэй.

Хэзээ мөдгүй газар хөдлөх хэмжээнд хүрчихсэн эрсдэлтэй нөхцөлд амьдарч байгаа нийслэлийн иргэд ядахдаа гамшиг тохиолдсон үед хаана байрлах вэ, хоол хүнс, тог цахилгаангүй, нийтийн унаа ч үгүй болбол хамгийн түрүүнд хэнд хандах юм бэ. Жил бүр л гамшгийн дохио дуугаргана, харин иргэд, албаны хүмүүс нь зөвхөн сургуулилтад л бэлтгэнэ. Хэрэв үнэхээр гамшгаас урьдчилан сэргийлэх дадал, мэдлэг мэдээллийг иргэддээ олгох гэж байгаа юм бол чичирхийлэл мэдрэгдсэний дараа яах ёстой, байшин барилга нь нурвал хаана хоргодох зэргийг нарийн зааварлах ёстой биш үү.

Нэг жишээ дурьдая. Газар хөдлөлтийн идэвхтэй бүс Японд хоргодох байрыг ногоон бөөрөнхий руу гүйж буй хүний дүрсээр тэмдэглэн оршин суугчдад зааварладаг. Хоргодох байрных нь тоо гэхэд улсын хэмжээнд нийтдээ 48 мянга гаруй байх бөгөөд үүний 944 нь засаг захиргааны байгууллага байдаг аж. Үүнээс халамж үйлчилгээ үзүүлэх байр 7647 байх бөгөөд үүний 791 нь төрийн байгууллага байдаг байх юм. Гэтэл нийслэлчүүд газар хөдлөл хаана очих, хэнд хандах талаар огт мэдээлэлгүй байна. Зарим хэвлэл нийслэлд хоргодох байр бий эсэх талаар албаны хүнээс тодруулахад, “төрийн нууцад хамааралтай харилах боломжгүй” хэмээсэн байх юм. Хоргодох байр хаана байрлах, аль аль сургууль, цэцэрлэгт хүрээлэнг хоргодох байрны зориулалтаар ашиглахыг нийтэд мэдээлээгүй байж, газар хөдлөлтийн гамшиг нүүрлэнэ гэж анхааруулж суугаа хүмүүс товчхондоо амь амиа бодоорой гэсэн мессэжийг л өгч байх аж.

Тийм байтал хоол хүнсний нөөцийн асуудлыг ярих ч боломжгүй. Нийслэлийн хэмжээнд Хустай, Авдрант, Мөнгөн морьт, Эмээлт, Гүнжийн ам, Шархай гэсэн зургаан бүс газар хөдлөлтийн идэвхтэй тооцогдог бөгөөд 6-7.2 магнитуд хүртэлх газар хөдлөлт болох магадлалтай. Одоон орон, геофизикийн хүрээлэнгийн эрдэмтэд тогтоосон байдаг. Гэтэл нийслэлд ийм хэмжээний газар хөдлөлт болох тэсвэрлэх төрийн үйлчилгээний барилга байгуулагаа, хувийн хэвшлийн компанийн барилга ч байхгүй. Ийм байтал хэчнээн дохио дугааргаад яах вэ дээ. Яг үнэндээ Гантигийн бодит жишээ манайд давтагдах вий дээ.

# ДЭЛХИЙ



## ФРАНЦЫН СОНГУУЛЬД НЭР ДЭВШИГЧИД ХАЛЗ МЭТГЭЛЦЛЭЭ

Б.ДАВАА

Францын Ерөнхийлөгчийн сонгууль ирэх дөрөв, тавдугаар сард болно. Тодруулбал, ирэх сарын 23-нд эхний шатны сонгуулийн санал хураалт болох бөгөөд хамгийн өндөр хувийн санал авсан нэр дэвшигчдийн хооронд шийдвэрлэх шатны сонгууль тавдугаар сарын 7-нд явагдах билээ. Тэгвэл сонгууль болоход сар орчим хугацаа үлдсэн энэ үед нэр дэвшигчдийн телевизийн халз мэтгэлцээн зохион байгуулагдлаа. Халз мэтгэлцээн орон нутгийн цагаар энэ сарын 20-нд болж, хэт барууны үзэл баримтлалт Үндэсний фронт намаас нэр дэвшиж буй Марин Ле Пен өрсөлдөгчийнхөө ширүүн дайралттай тулгарчээ. Тэрбээр хамгийн сүүлийн үеийн санал асуулгад нэлээд өндөр рейтингтэй яваа бөгөөд Европын холбооноос гарах, цагаачлалын эсрэг хатуу бодлого баримтлана гэх амлалтыг мөрийн хөтөлбөрийнхөө гол заалт болгож буй юм.

Халз мэтгэлцээнийг “TF1” телевиз зохион байгуулсан бөгөөд Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвшиж буй таван эрхмийг оролцуулж, өөр өөрсдийнх нь баримтлага бодлого чиглэлийнх нь талаар мэтгэлцүүлсэн байна. Улмаар оролцогсдын хоорондын мэтгэлцээн дүрвэгсэд, шашин шүтлэгийн асуудалд ширүүсчээ. Өмнөх Францын үе үеийн төрийн тэргүүнд нэр дэвшигчдийн хооронд энэ удаагийнх шиг ширүүн мэтгэлцээн болж байгаагүй гэдгийг “Франц пресс” мэдээллээ.

Энэ удаагийн үйл ажиллагаанд бие даан нэр дэвшигч Э.Макрон, Бүгд найрамдах намаас нэр дэвшигч, Ерөнхий сайд асан Франсуа Фильон, Социалист намын Боловсролын сайд асан Бенойт Хамон, Зүүн жигүүрийн намын Жан Люк Меленчон, Үндэсний фронт намын Марин Ле Пен гэсэн таван эрхэм оролцжээ.

Францын Ерөнхийлөгчийн сонгуульд нийтдээ 11 нэр дэвшигч өрсөлдөж байгаа. Гэхдээ мэтгэлцээнд улс төрийн жижиг хүчний зургаан төлөөллийг оролцуулаагүй байна. Мэтгэлцээний үеэр популист улстөрийн хүчин болох Үндэсний фронт намын нэр дэвшигч Марин Ле Пений дүрвэгсэд цагаачлалын эсрэг бодлогыг бусад нь эрс ширүүн шүүмжилж, хэд хэдэн удаа хатуухан дайралт хийгээд амжсан байна. Тухайлбал, Ле Пен “Терроризмын аюулаас улс эх орноо хамгаалахын тулд дүрвэгсдийн урсгалыг зогсоох ёстой” хэмээгээд, Франц дахь лалын шашны байгууллагын тоо нэмэгдэж, тус улсын аюулгүй байдал ноцтой хэмжээнд хүрснийг онцолжээ. Харин түүний байр суурийг Э.Макрон үгүйсгэж, “Ле Пен улс орныг хуваахыг хүсч байна” гэж шүүмжилсэн байна.

Мөн Ле Пен Францын эдийн засаг Германы ард бичигдэх болсон нь Европын холбооны өнөөгийн байдал болон еврог гүйлгээнд ашиглаж эхэлснээс шалтгаалсан гэжээ.

Францын иргэдийн дунд явуулсан хамгийн сүүлийн үеийн санал асуулгаар ирэх дөрөвдүгээр сарын 23-ны өдөр явагдах эхний шатны сонгуулийн санал хураалтад Э.Макрон, Марин Ле Пен нар тэргүүлэх төлөв ажиглагджээ. Харин тавдугаар сард болох шийдвэрлэх шатны сонгуульд Макрон ялалт байгуулж, Ерөнхийлөгч болох магадлал өндөр байгаа гэнэ. Гэхдээ судалгаанд оролцогсдын 40 орчим хувь нь хэнийг дэмжихээ хараахан шийдээгүй гэж хариулсан тул сонгууль хаашаа эргэхийг одоогоор таамаглах боломжгүй байна.

## Рекс Тиллерсон ОХУ-д айлчилна

АНУ-ын Төрийн нарийн бичгийн дарга Рекс Тиллерсон дөрөвдүгээр сард Италид болох “Их-7”-гийн орнуудын Гадаад хэргийн сайд нарын уулзалтад оролцсоныхоо дараа ОХУ-д айлчлах ажээ. Энэ тухай АНУ-ын Төрийн Департаментын төлөөлөгч мэдээллээ.

Ирэх лхагва гарагт Р.Тиллерсон НАТО-гийн гишүүн орнуудын Гадаад хэргийн сайд нартай уулзана. Төрийн Департаментад болох эдгээр уулзалтууд нь “Лалын улс” бүлэглэлийг дарахаар тэмцэж буй терроризмын эсрэг эвсэлд багтсан орнуудын уулзалтын хүрээнд болж байгаа юм.

Үүнээс өмнө “Reuters” агентлаг мэдээлэхдээ, Р.Тиллерсон Москвад дөрөвдүгээр сарын 12-нд очно гэснийг АНУ-ын Төрийн Департамент нотолсонгүй. Тэрбээр дөрөвдүгээр сарын 5-6-нд Брюссельд болох НАТО-гийн гишүүн 28 орны Гадаад хэргийн сайд нарын уулзалтанд оролцох боломжгүй болсон байна. Учир нь энэ үеэр БНХАУ-ын дарга Си Зиньпин АНУ-д айлчлах ажээ.

## Иванка Трамп Цагаан ордонд өрөөтэй болжээ

АНУ-ын Ерөнхийлөгч Доналд Трампын том охин Иванка Трамп Цагаан ордонд өөрийн гэсэн ажлын өрөөтэй болжээ. Гэхдээ Засгийн газрын ямар нэг албан тушаалд томилогдохгүй гэнэ.

Үл хөдлөх хөрөнгийн тэрбумтан Доналд Трамп АНУ-ын Ерөнхийлөгч болж, тангаргаа өргөснөөс хойш Иванка Цагаан ордны баруун жигүүрт үе үехэн харагдаж, томоохон уулзалтад оролцож байсан юм. Саяхан гэхэд Германы канцлер Ангела Меркелийн Д.Трамптай хийх уулзалтад ч Иванка оролцсон удаатай. Тэгвэл эдүгээ бүсгүй Цагаан ордонд өөрийн гэсэн ажлын өрөөтэй болж, улс төрийн холбогдолтой нууц мэдээллийг авах эрхтэй болсноос гадна, Ерөнхийлөгчийн зөвлөхтэй адил үүрэг гүйцэтгэхээр болсон байна. Энэ талаар түүний өмгөөлөгч Жэйми Горелик “Политико” сайтад ярьжээ. Тэрбээр “Ерөнхийлөгчийн том хүүхэд эцгийнхээ засаг захиргааны ажилд оролцдог байсан тохиолдол /прецедент/ өмнө нь гарч байсан. Хэдийгээр Иванка төрийн тэргүүний зөвлөх биш ч гэсэн сайн дураараа Ерөнхийлөгчийн зөвлөхийн үүргийг гүйцэтгэх юм” гэсэн байна.




Иванка Трампын нөхөр Жаред Кушнер ч гэсэн хадам эцгийнхээ зөвлөхөөр ажиллаж буй билээ. Ж.Кушнер өмнө нь төрийн байгууллагад ажиллаж байгаагүй төдийгүй, улс төрд хүчин зүтгэсэн туршлагагүй нэгэн юм.

ХОРЛОО ЭМЧИЙН БУЛАН



## Бэлгийн сулрал

*Энэ удаагийн “Хорлоо эмчийн булан”-гаараа эрэгтэйчүүдэд тулгамддаг бэрхшээлүүдийн нэг болох бэлгийн сулралын талаар та бүхэнд хүргэх гэж байна. Хүн бүхэн эрүүл мэнддээ анхаардаг болсон энэ цаг үед “Godsend” эмнэлгийн Бөөр, бөөрний мэс засал, эрэгтэйчүүдийн зөвлөх эмч Ж.Хорлоо эрхэм уншигч танд хэрэгтэй тун чухал зөвлөгөөнүүдийг бэлтгэн хүргэж байгаа билээ. Мөн та Ж.Хорлоо эмчээс асуух зүйлээ https://www.facebook.com/godsend.hospital.1?fref=ts хаягаар зурвас илгээх буюу “Godsend” эмнэлгийн 80123807, 88780665 дугаарын утсаар тодруулаарай.*

Эрэгтэй хүний хэвийн бэлгийн үйл ажиллагааны хямралыг бэлгийн сулрал гэнэ. Судалгаанаас үзэхэд эрдэмтэн Ю.И Кушнирук, А.П Шербаков нарын судалгаагаар эрүүл гэж тооцогдох гэр бүлийн 60.3 хувь нь бэлгийн харилцааны ямар нэг бэрхшээлтэй байсны 40.5 нь бүр анх гэрлэх үеэсээ 19.8 хувь ямар нэг хожуу тохиолдсон шалтгаанаас болсон байжээ. Тэдгээр гэр бүлийн 46.2 хувь нь эмч, мэргэжилтний буюу өөрсдийн хүчээр уг байдлыг давж чадсан бол 14.2 хувь нь гэр бүл салахад хүрсэн байна.

Бэлгийн сулралын тухайд сэтгэцийн нөлөөт бэлгийн сулрал 25 хувийг эзэлдэг бол бие махбодь эрхтэн системийн органик өөрчлөлтөөс болсон тохиолдол 25, холимог ангиллынх нь 50 хувийг эзэлж байна. Сэтгэцийн нөлөөт бэлгийн сулрал анхдагч буюу тогтмол байх, хоёрдогч буюу үе үе илрэх зэрэг шалтгаантай бол бие махбодь эрхтэн системийн органик өөрчлөлтөөс болсон тохиолдолд нөхөн үржихүйн эрхтний өөрчлөлт (түрүү булчирхай ба төмсөг дайврын үрэвсэл гэх мэт), нуруу аарцаг ясны гэмтлийн үед мэдрэлжүүлэлт цусан хангамж алдагдах, хорт зуршил (архи, тамхи, мансууруулах бодис) зэрэг шалтгаантай байна.

Бэлгийн сулралын үед бэлэг эрхтний хөвчрөлтийн гажиг, үрийн шингэн гадагшлуулах үйл ажиллагааны буюу дур тавилтын өөрчлөлт, бэлгийн дур хүсэл буурах, аарцгийн хөндийн болоод нөхөн үржихүйн эрхтний гэмтэл, мэс засал зэрэг шинж тэмдгээр илэрнэ.

Сэтгэцийн нөлөөт шалтгаанд сэтгэл мэдрэлийн өвчин, бэлгийн гаж дон, сэтгэлийн дарамт цочрол, мэдрэлийн сульдаа болно. Харин эрхтэн системийн өвчлөл өөрчлөлтөд судасны эмгэг, судас хатуурах, нарийсах 40, чихрийн шижин 30, эмийн нөлөө-нэг эм удаан хугацаагаар уух 15, мэдрэлийн өвчин 10, аарцаг, эрхтний мэс засал ба гэмтэл 8, дотоод шүүрлийн булчирхайн үйл ажиллагаа алдагдах 3, бусад 1 хувиар алдагдана. Холимог шалтгаант бэлгийн сулрал нь бие махбодийн өөрчлөлтөөс болж бэлгийн сулралд ороод түүндээ санаа зовж, сэтгэл тавгүй болсноор давхар сэтгэцийн нөлөө үүснэ. Үүнд бэлгийн амьдралд хамтраг оролцогчийн зүгээс үзүүлэх хандлага их нөлөөтэй.

Оношийг үнэн зөв, бүрэн тогтоосны үндсэн дээр өөрөөр хэлбэл, бэлгийн сулралын шалтгааныг тодорхой болгоод эмийн, мэс заслын болон сэтгэлзүйн аргуудаас оновчтойг нь сонгон авч тохируулан эмчилснээр үр дүнд хүрэх боломж бүрдэнэ. Энэ бол зөвхөн нарийн мэргэжлийн эмч нарын маш нарийнь өндөр хяналтад хийгдэх ажил юм. Гэтэл ихэнх хүмүүс хэд хэдэн үндсэн алдаануудыг гаргаснаар уг эмгэгээ эмчлэх гэж ямар ч үр дүнгүй оролдлого хийдэг. Тухайлбал, бусдыг дуурайн, хэн нэгний амаар эмчлэх гэж оролдох, энэ талаар тодорхой мэдлэг муутай мэргэжлийн бус эмч нарын зөвлөснөөр оновчтой бус эмчилгээ хийлгэх, түр зуурын нэг удаагийн үйлчилгээтэй эм хэрэглэх зэрэг оролдого хийх хэрэггүй юм. Учир нь дээр дурьдсан бүхэн үндсэн шалтгааныг арилгаж чадахгүй, харьцангуй залуу хүмүүс бэлгийн дааврын (гормон) шинжилгээгүйгээр, даавар дур мэдэн эрт хэрэглэх нь алсдаа байдлыг улам муутгадаг гэдгийг сануулж байна.


## ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: **2017оны 03 дугаар сарын 22**
Тендер шалгаруулалтын нэр: **Үндэсний батлан хамгаалахын их сургууль, Цэргийн төв эмнэлгийн хэрэгцээт хувцас хэрэглэл нийлүүлэх**
Тендер шалгаруулалтын дугаар: **БХЯ/201700002**

**Батлан хамгаалах аж үйлдвэрийн нэгдэл ТӨААТҮГ** эрх бүхий тендерт оролцогчдоос хувцас хэрэглэл нийлүүлэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдлээр нь **50,000** төгрөг, эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний чөлөөтэй хөрвөх валютаар худалдан авч болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **[45]** хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

Үүнд:

**Борлуулалтын хэмжээ:** Багц тус бүрийн хувьд санал болгож байгаа үнийн дүнгийн 100%-ийн үнийн дүнтэй тэнцүү хэмжээний борлуулалтын орлоготой байх.

**Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ:** Багц тус бүрийн хувьд санал болгож байгаа үнийн дүнгийн 100%-ийн үнийн дүнтэй тэнцүү хэмжээний түргэн хөрвөх чадвартай хөрөнгөтэй байх.

Тендерийн хамт 1-р багцад 1 587 084 төгрөг, 2-р багцад 408 850 төгрөг, 3-р багцад 221 065 төгрөг, 4-р багцад 290 700 төгрөгийн тус тус дүнтэй банкны баталгаа ирүүлнэ.

Тендерийг **2017 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 11.00 цагаас өмнө** доорх хаягаар ирүүлэх ба тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг **2017 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 11.30 цагт** Батлан хамгаалах аж үйлдвэрийн нэгдэл ТӨААТҮГ-ын байрны 1 давхрын хурлын танхимд нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй.
Дотоодын давуу эрх тооцно.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно. Тендерийн баримт бичиг худалдан авах үнийг БХАҮН ТӨААТҮГ-ын Хаан банкин дахь 50 99 98 00 55 тоот дансанд тушаана.

**Баянзүрх дүүрэг, Дандарбаатарын гудамж, 16 дугаар хороо, Засгийн газрын 7 дугаар байрны дэргэд Батлан хамгаалах аж үйлдвэрийн нэгдэл ТӨААТҮГ-ын байрны 2 давхрын 2 тоот өрөө.**
**Утас: 95584084, Г.Хандмаа**



## “БАЯНГОЛ ЗОЧИД БУУДАЛ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

“Баянгол зочид буудал” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2017 оны 4-р сарын 27-ны өдрийн 16.00 цагт компанийн Баянгол рестораны зааланд хуралдана.

Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдөр: 2017 оны 4 дүгээр сарын 07-ны өдөр

**ХУРЛААР ДАРААХ АСУУДЛЫГ ХЭЛЭЛЦЭНЭ:**

1. Компанийн 2016 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлт.
2. Компанийн 2017 оны бизнесийн үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах
3. ТУЗ-ийн 2017 оны зардлын төсөв

Хувьцаа эзэмшигчдийн хурлын талаархи дэлгэрэнгүй мэдээллийг өөрийн үйлчлүүлдэг БДК дээр болон компанийн өөрийн байранд ажлын өдрүүдэд (Даваа-Баасан) 9:00 цагаас 16:00 цаг хүртэл авах боломжтой.

**Хурал зохион байгуулах комиссын дарга: Д.Цэнддорж**
**Тооллогын комиссын дарга: Т.Бичигмаа**

Хурлын байр: Баянгол Зочид Буудал, Сүхбаатар дүүрэг, Чингисийн өргөн чөлөө-5
Электрон шуудан: lhagvatserennadmid@bayangolhotel.mn
Харилцах утас: 312255, 326778

**ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС**

# ОНЦЛОХ ХУУДАС

## Speak out



# ТЭТГЭВРИЙН НАС ТЭЭР ТЭНД БАЙНА

Б.АЛТАНБАГАНА
З.МӨНХСУВД

Сангийн яамнаас ОУВС-тай хамтран мэдээлэл хийхдээ 2037 он гэхэд тэтгэврийн нас 65 болно гэж мэдэгдсэн. Тиймээс ч олон нийтийн дунд 2037 оноос тэтгэвэрт гарах насны хэмжээ өөрчлөгдөнө гэсэн ойлголт бий болсон. Түүнчлэн төсвийн тодотголд тэтгэвэрт гарах насыг 2018 оноос хойш жил бүр зургаан сараар нэмэгдүүлэхээр тооцсон бөгөөд цаашид өсөх эрэмбээр явах юм байна. Ингэснээр 2027 он гэхэд эрэгтэй 65, эмэгтэй 55-60 нас хүрч тэтгэвэрт гардаг тогтолцоонд бүрэн шилжсэн байх аж. Мөн дөрвөн хүүхэд төрүүлж, алдарт эх болсон эмэгтэйчүүд одоогийн зохицуулалтаар 50 нас хүрээд тэтгэвэрт гарч буй. Тэгвэл ирэх оноос хойш энэ тоо зургаан сараар өгссөөр 2027 онд алдарт ээжүүд 55 нас хүрч тэтгэвэрт гардаг тогтолцоонд бүрэн шилжинэ. Тэтгэврийн насны энэ шинэчлэл 2027 онд хүрээд зогсчихгүй. Алдарт эхийн болзол хангаагүй эмэгтэйчүүд мөн оноос зургаан сараар өгссөөр 2037 онд гэхэд эрчүүдтэй адилхан 65 нас хүрч байж тэтгэвэрт гардаг тогтолцоонд шилжих учиртай. Гэтэл хамгийн сүүлийн үеийн статистикийн дүн мэдээллээр монголчуудын дундаж наслалт 69 хэмээн бүртгэгдсэн байдаг. Тиймээс бид өнөөдрийн “Speak out” буландаа тэтгэврийн насыг нэмэх нь зөв эсэх талаар иргэд ямар байр суурьтай байгааг сонирхлоо.

*Гэрэл зургийг Г.АРГУУЖИН*



### С.Сарантуяа: Нийгмийн даатгалд төлсөн мөнгөө авч чадахгүй бүгд үхээд дууссна

*/Сүхбаатар дүүргийн иргэн/*

-60 хүрч байгаа хүн Монголд байна уу. Бараг л байхгүй дээ. Залуучууд үсрээд л 50 наслаад, харваад үхээд байна. Тэгж байхад тэтгэврийн насыг 60 болгоно гээд байгаа. Нийгмийн даатгалд төлсөн мөнгөө авч чадахгүй бүгд үхээд дуусах нь байна. Амьдрал дээр 70 наслаж байгаа хүн ховор шүү. Бүгд л хавдартай гэж байна. Элэгний хавдраараа дэлхийд хоёрт орж байгаа манайх шиг орны хүмүүс 60-65 настайдаа тэтгэврээ тогтоолгоод хэзээ нь сайхан амьдрах юм бэ. Нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгал гэсэн нэрийн дор татвар авч байна. Үүнийг нь төлөөд байхад ямар ч хөнгөлөлт үйлчилгээ үзүүлж байгаа юм байхгүй. Бидний хувьд даатгалын шимтгэл төлсний үр дүн гэж гарахгүй байна шүү дээ. 20 жилийн турш өдөржингөө гадаа зогсож байгаа над шиг хүн 60 битгий хэл одоо эмнэлэгт үзүүлэхээр тийм ч үрэвсэл, ийм ч дутагдал гээд өвчин салахгүй байхад тэтгэвэр авч чадна гэдэгтээ эргэлзэж л явна. Одоо яах вэ, амьдрахын эрхэнд өвчтэйгөө мэдсэн ч ажиллаад явж л байна. Юуны тулд юм бэ. Хэдэн хүүхдэдээ лай болчихгүй, үхлээ гэхэд оршуулгын мөнгөө хийж байж үхмээр байна. Амьдралын үнэн энэ л байна.



### Ч.Баттулга: Ач, гучийнхаа дэргэд хамтдаа жаахан баймаар л байна

*/Сүхбаатар дүүргийн иргэн/*

-60-65 хүртлээ ажилласаар байгаад олигтойхон шиг амарсан юм байхгүй нөгөө ертөнц рүү явчихна шүү дээ. Би одоо 53 настай. Шинэ хуулиар бол дахиад 18 жил ажиллаж байж тэтгэврээ тогтоолгох нь ээ дээ. Бас л хол сонсогдож байна. Бараг 60 настайдаа гардаг нь ахдаад байхад дахиад тавыг нэмчихээр тун хэцүү байна. Өмнө нь тэтгэврийн насыг нэмж байхад яаж дахиад хэдэн жил нэмж ажиллана даа гэж бодож сөргөөр хүлээж авч байсан. Одоо энэ хуультай эвлэрэхгүй байна. Өтөлж байна. Ач, гучийнхаа дэргэд жаахан ч гэсэн хамтдаа баймаар л байна шүү дээ. Ингээд ажиллаад явж байтал 65 хүрээ ч үү, ажилд аваа ч уу, хэн мэдлээ. 35 хүрээд л ажил олгогчид хөгширчихлөө гээд халаад хаячихаж байхад 65 нас хүртэл ажиллуулах газар байх уу. Бор зүрхээрээ аргацаахгүй л бол өөр арга байхгүй. Бас нөгөө талаараа ийм утаатай, бохирдолттой, эрүүл байх баталгаа байхгүй оронд амьдарч байгаа хүмүүс насаараа ажиллаж байгаад насны эцэст тэтгэвэр ч үгүй үхчихвэл хайран биз дээ. Ийм орчинд байгаа бид урт насална гэдэг мөрөөдөл. За тэгээд, тэтгэвэр авна гэдэг бүр өдрийн од шиг нандин зүйл болох юм байна л даа гэж бодож байна.



### Э.Энх-Амгалан: Ард түмний амьдралыг даапаалаад байгаа юм уу, хаашаа юм

*/Баянзүрх дүүргийн иргэн/*

-Монгол хүний дундаж наслалт хэд билээ, үүнийг бодоод үзэхээр ингэж хууль батлах нь тэнэг байхгүй юу. Зүгээр л аргацаасан ажил хийцгээж байна шүү дээ. Тэтгэврийн насыг 60-65 хүргэх юм бол монголчууд бүгд тэтгэвэр авч чадахгүй үхээд дуусна. Зарим нэг хүмүүс нь 60 хүрэхгүй үхчихэж байна. Өвчлөл, хавдар залуужиж байна. Энэ нь чанартай бүтээгдэхүүн хэрэглэж чадахгүй байгаагаас л үүдэлтэй. Орчин нөхцөл нь ийм байхад тэр гадаадын өндөр хөгжилтэй орнуудтай өөрсдийгөө харьцуулаад байх юм даа. Ингээд насыг нь нэмчихээр зарим хүмүүсийн амьдралын идэвх, ажлын бүтээмж ч суларна шүү дээ. Ард түмний амьдралыг даапаалаад байгаа юм уу, хаашаа юм. Өөрсдөө идэж, уусныг үнэн мөнөөр нь илчлээд, төлчихвөл бидэнд ийм хүндрэл учрахгүй байхгүй юу. Ард түмний толгойд төрөөс биднийг гэсэн дорвитой алхам хийхгүй гэдэг бодол бат суучихсан. Уг нь УИХ-ын гишүүд сонгогдохоосоо өмнө бараг л алган дээрээ бөмбөрүүлнэ гэж амлаад байсан нь шал худлаа.



### Н.Энхтуяа: 60 настайдаа тэтгэвэрт гарахаар болчихвол эгчийнх нь бие дийлэхгүй ээ

*/Сонгинохайрхан дүүргийн иргэн/*

-Уг нь эгч нь дөрвөн хүүхэдтэй. Тэгээд 50 настайдаа тэтгэврээ тогтоолгох байсан. Гэтэл нас болоогүй байна, 55 хүрч байж тэтгэвэрт гар гээд халгаахгүй байна. Тэгснээ нийгмийн даатгалын шимтгэлээ бүр өндрөөр төл гэсэн. Энэ нь сардаа 70-80 мянган төгрөг болох юм шиг байна билээ. Зүгээр хувь тэнцүүлэхээр орно гэвэл сардаа 30 мянгыг төлөх юм уу даа. Одоо бүр 60 настайдаа тэтгэвэрт гарахаар болчихвол эгчийнх нь бие дийлэхгүй ээ. Дундаж наслалт 75-80 байхад 45-50 настайд тэтгэвэрт гаргадаг байсан. Гэтэл одоо дундаж наслалт 65-70 болчихоод байхад 65 хүргэж байж тэтгэвэрт гаргана гэдэг бараг тэтгэврийг байхгүй болгох гээд байгаа хэрэг юм уу. Хийдгээ хийгээд өндөр насныхаа амралтад гарах цаг нь болчихоод байхад ингэж чагтална гэдэг чинь байж болохгүй хэрэг. Төр засаг ард иргэдийнхээ халаас руу орохгүй гэж хэлчихээд жинхэнээсээ орж байна шүү дээ.



### Б.Батболд: Тэтгэвэрт гартлаа бид өртэй юм шиг амьдарна гэсэн үг үү

*/Сонгинохайрхан дүүргийн иргэн/*

-Ах нь тэтгэвэрт гарах болоогүй л дээ. Гэхдээ хэрвээ шинээр гарч байгаа хууль хэрэгжээд эхэлчих юм бол миний тэтгэвэрт гарах үед тэтгэврийн нас аль хэдийнэ 65 болчихно. Тэгэхээр нэлээд хүндрэл гарах байх. Гэхдээ 65 настайдаа тэтгэвэрт гарлаа гэхэд хэр удаа аж дээ. Үсрээд л 70 хүрэх байх. Бараг 70 насыг давж насалдаг хүн ховордсон цаг шүү дээ. Ийм байхад тэтгэврийн насыг нэмчихээр яах болж байна. Энэ бараг эдийн засагт ачаалал өгөхгүй, төсвөө хэмнэх гэсэн нэг төрлийн бодлого л байх. Нөгөө талаараа үнэхээр 65 нас гээд тогтоочих юм бол тэр хүртэл нь нийгмийн даатгал төлнө гэсэн үг. Тэгэхээр тэтгэвэрт гартлаа бид өртэй юм шиг амьдарна гэсэн үг үү. Энэ бол үнэндээ биднээс авах татварын нэг хэлбэр л юм байна.



### А.Бадамсүрэн: Хөдөлмөрийн чадвартай байгаа дээрээ ажил хийгээд явахад юу нь болохгүй гэж

*/Хан-Уул дүүргийн иргэн/*

-Зарим хүмүүс ажиллаад байх л санаатай байдаг юм байна лээ. Иргэдийн санаа бодол хоёр хуваагдах л байх. Нэг хэсэг нь эрт тэтгэвэрт гарчих гээд л, нөгөө хэсэг нь болж өгвөл ажиллах гээд л байна байх. Миний хувьд хэрвээ энэ хууль яг хэрэгжээд эхэлчихвэл хуулиа л дагах байх даа. Хөдөлмөрийн чадвартай байгаа дээрээ ажил хийгээд явахад юу нь болохгүй гэж. Гэхдээ иргэдийнхээ дундаж наслалт, ямар орчинд байгааг нь бодох л хэрэгтэй. Үнэхээр хүнд нөхцөлд ажил хөдөлмөр эрхэлдэг хүмүүсийн хувьд энэ нь хэцүү асуудал л даа. Гэхдээ мань мэтийн дураар болоод хуулиа өөрчилнө гэсэн юм байхгүй байх л даа. Тиймээс хуулиар юу гэж тогтооно түүнийг нь хэрэгжүүлэхийг л бодно.



### О.Батцэцэг: Тэтгэврийн насаа хүлээж байгаа зөндөө л хүн байгаа

*/Налайх дүүргийн иргэн/*

-Монголчуудын дийлэнх нь хар бор ажил хийдэг. Тэгэхээр 60 хүртлээ биеийн хүчний ажил хийхээр чинь тэр хүнээс эрүүл зүйл үлдэх үү. Бодоод үзэхээр эрүүл мэндийн хувьд яагаад ч таарамжгүй. 30 жил гэдэг чамлахааргүй урт хугацаа, үүнийг 40 болгоно гэдэг бас л чанга хэрэг дээ. Би энэ жил 55 нас хүрч тэтгэвэрт гарах ёстой, зургадугаар сараас тэтгэврээ тогтоолгох санаатай байсан юм. Одоо тэтгэврийн нас нэмэгдчихвэл бас яаж таван жил нэмж ажиллана даа гэж бодож байна. Надтай адилхан тэтгэврийн насаа хүлээж байгаа зөндөө л хүн байгаа байх. Тэдгээр хүмүүсийн ихэнх нь энэ хэрэгжих хуулийг эсэргүүцэх л байх даа.



### Л.Тэрбиш: Монголд бараг тэтгэвэр авах хүн олдохгүй болно

*/Баянзүрх дүүргийн иргэн/*

-Энэ ерөөсөө хамгийн буруу ажил. Ингээд нэмчихээр Монголд бараг тэтгэвэрт гарах хүн олдохгүй болно биз дээ. Насандаа хүрч чадахгүй тамаа цайна л гэсэн үг. Ийм боомилсон ажил хийж болохгүй. Энэ хуулийг ер нь дэмжих хүн байхгүй. Би хувьдаа эсэргүүцэж байна. 60 нас хүрч тэтгэврээ тогтоолгох гэж зовж байхад 65 болчихвол зүгээр хоосон үх гэж хэлж байгаагаас ялгаагүй хэрэг болно. Иргэд ч гэсэн ярьж байна лээ. 60 нас бол нэлээд өндөр насжилттайдаа тооцогдохоор болсон гэж. Ийм утгагүй зүйл гэж юу байдаг юм. 30 жил улсдаа шударгаар хөдөлмөрлөөд амарвал болоо юм биш үү. Ингэж төсвөө хэмнэнэ гэж байх уу.

### Б.Гарамханд: Тэтгэврийн насыг нэмэх биш наашлуулах хэрэгтэй шүү дээ

*/Баянзүрх дүүргийн иргэн/*

-Тэтгэврийн насыг нэмнэ гээд зурагт, радиогоор яриад байгаа. Энэ их буруу зүйл. Бид татвараа цаг тухайд нь төлөөд явдаг. Гэтэл яагаад тэтгэврийн насыг наашлуулаад хэдэн төгрөг олгочихож болдоггүй юм. Монголын ард түмэн байнга л өрнөөс өрний хооронд амьдарч байна. Ядаж тэтгэвэр аваад байх юм бол арай гайгүй шүү дээ. Үр хүүхдээ сургууль соёлд сургах, хоол ундны мөнгө, төгрөг гээд маш олон асуудал байна. Түүгээр ч зогсохгүй манай улсад ажлын байрны хомсдол их байгаа. Сургууль соёл төгссөн эрдэм, мэдлэгтэй хүмүүс ажилгүй байхад бидэн шиг хүмүүсийг угаасаа ажилд авахгүй. Ойр зуурын чихэр, жимс зарж хоол ундны мөнгөө залгуулж байна даа. Төр засаг минь ард түмнээ бодох цаг болсон л баймаар юм. Тэтгэврийн насыг нэмэх биш наашлуулах хэрэгтэй шүү дээ.

### Т.Баасанхүү: 65 настай хүнээр улс юу хийлгэх гээд байгаа юм бэ

*/Чингэлтэй дүүргийн иргэн/*

-Ард түмнээ элгээр нь мөлхүүлж байж одоо бүр дээрээс нь дэвсэлж байгаа юм уу. Яаж өөд нь татах вэ гэж бодохын оронд иргэдийн хөдөлмөр, мөнгийг шулаад улсаа аварна гэсэн зүйл байхгүй шүү. Үүнийг хатуу хэлчихье. Сайн бодлого дор зөв удирдаж байж улс хөгжинө үү гэхээс шахаж, албан хүчээр ажил хийлгэж, боомилж байж хөгждөг түүхийг би мэдэхгүй. Ингээд тэтгэврийн насыг нэмчихээр хэн ч сэтгэл гаргаж, тэр ажлыг чанартай хийхгүй. Зүгээр хэдэн жилийг яаж ийгээд тооцуулах юмсан л гэж бодож ажиллана уу гэхээс омголон залуу насных шигээ их бүтээн байгуулалтын төлөө гэж сэтгэл гаргаж ажиллах хүн байхгүй. Сэтгэл гаргаад ажиллая гэсэн ч чадал нь хүрэхгүй. Ер нь 65 настай хүнээр улс юу хийлгэх гээд байгаа юм бэ.

## ДУГААРЫН СУРВАЛЖЛАГА



Гэрэл зургийг Г.АРГУУЖИН

# Газар хайсан иргэд АМИАРАА

Н.БАТЗАЯА

Өнөөдөр мягмар гараг. Энэ өдөр ажлын өдөр хэдий ч Баянзүрх дүүргийн X хорооны иргэд гудамжиндаа хүрз, дэрсэн шүүр барин тун завгүй ажиллах аж. Учир нь тус хорооны нутаг дэвсгэрт оршин суух айл өрхүүд булгийн эхэнд шороо асган суурьшсанаас болж хөрсний ус шахагдан халиа үүсч хашаа хороо, гэр орон тэр бүү хэл байшин, автомашины орой цухуйх төдий их хэмжээний усанд автаж, ойр орчимд нь амьдардаг иргэдэд аюултай байдал үүссэн билээ. Тухайн үед нийслэл, дүүргийн Онцгой комиссын хамтарсан хуралдаан болж булгийн халиа, дошин бүхий гамшгийн нөхцөл байдалд яаралтай арга хэмжээ авах үүрэг өгснөөр НОБГ-аас усыг соруулж суурьшлын бус бүсэд асгах, оршин суугчдыг аврах, болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч байв. Гэсэн хэдий ч урин дулаан цаг ойртохтой зэрэгцээд их хэмжээний хөлдсөн ус хайлж, ойр орчмын айлууд үерт автаж болзошгүй нөхцөл байдал үүсээд байгаа нв энэ аж. Тиймээс “Монголын мэдээ” сонин энэ удаагийн “Дугаарын сурвалжлага”-аараа Баянзүрх дүүргийн X хороо буюу “Амгалан” дулааны станцын зүүн хойд хэсэгт оршин суух айл өрхүүдийн нөхцөл байдлыг сурвалжиллаа.

### Мөсөөр хүрээлэгдсэн монгол гэрт амьдрал үргэлжилж байна

Бидний хэлж заншсанаар Ботаникийн автобусны буудлаас хоёр орчим км зайд булгийн усанд автсан хэсэг айлууд байрлана. Тус автобусны буудлаас хөдлөөд км хүрэхгүй зайнаас эхлээд булгаас урссан ус энд тэнд тогтож хөлдсөн харагдав. Энд нөхцөл байдал гайгүй хэдий ч гудамжинд бороо орсон мэт шалбааг тогтсон нь урин дулаан цаг, түүнийг дагаад багагүй аюул ойртож буйг илтгэнэ. Харин булгийн эхэнд суурьшсан айлууд руу ойртох тусам нөхцөл байдал улам хүндэрч байлаа. Бид нарийхан ухсан шуудуug дагаж явсаар нэгэн худгийн хажууд ирсэн ч сууж явсан машин маань цааш явах боломжгүй болсон юм. Машинаас буун хартал баруун талын хашааг дагуулан ухсан шуудуугаар мөстэй булингартсан ус урсах бөгөөд хэсэг хүмүүс мөсийг хүрзээр доош гүйлгэн урсгана. Тэдний дунд иргэд төдийгүй Геодези усны барилга байгууламжийн газрын ажилчид ч байв. Шуудуу даган урсах ус хүний хөлийн эрээн булчинг даван цалгилж харагдав. Мөстэй хүйтэн усан дотор усны гуталтай хэдэн цаг зогсож, ард иргэдийн аюулгүй байдлын төлөө ажиллах Геодези усны барилга байгууламжийн газрын ажилчдыг хараад өөрийн эрхгүй бахархах сэтгэл төрж байсныг нуух юун. Ингээд манай сурвалжлах хэсэг машинтай явах боломжгүй болсон учраас хөлдсөн мөсөнд дарагдсан гудамжаар цааш алхлаа. Гудамжинд тогтож хөлдсөн ус захаасаа хайлмагтаж эхэлсэн ч монгол гэрийг тойроод зузаан мөсөн бүрхүүл үүссэн нь хашааны завсраар нүдэнд илхэн харагдана. Хоосон хүн амьдардаггүй монгол гэр бол яая гэх вэ. Гэвч мөсөөр хүрээлэгдсэн монгол гэрт амьдрал үргэлжилж байгаа нь яндангаар суунаглан гарах утаанаас нь илхэн. Тэр гэрт өглөө, өдөр цэцэрлэг, сургуульдаа явах бяцхан багачууд өсөн торниж буй. Мөн нэгэн айлын хашааны үүдэнд хүн авчираад тавьчихсан юм шиг явган сандалны хэмжээтэй мөс байх юм. Мөсөн дээр гишгэн хашаан доторх байдлыг ажиглавал мөн адил хашааны тэн хагас нь усанд автаж, хөлдсөн харагдав. Тэр чигтээ мөсөн коток болсон энэ хэсэгхэн газрын мөс эхнээсээ хайлж, голын ус хоржигнож буй мэт дуу чимээ чихэнд дэлсэнэ. Энэ чимээг анх сонссон хүмүүст хэзээ мөдгүй их ус нүргэлэн орж ирэх гэж байгаа ч юм шиг сэтгэгдэл төрөхөөр. Энд бид Геодези усны барилга байгууламжийн газрын инженер, техникийн ажилтан Д.Гөлөгдэмбэрэлтэй ярилцсан юм. Түүний хэлсэнчлэн Геодези усны барилга байгууламжийн газар энэ сарын 20-нд Нийслэлийн онцгой байдлын газраас энэхүү ажлыг хүлээн авсан гэнэ. Тэрбээр “Манай байгууллага өчигдөр энэ ажлыг шилжүүлэн авсан. Өвөл булгийн ус халих үед шороон далан барьж, ойр орчмын айлууд руу ус орохоос сэргийлсэн юм. Одоогийн байдлаар бид шороон даланд тогтсон мөсийг зөөж, гол руу хаях арга хэмжээг авч байна. Инженер, техникийн ажилчин гээд нийт 13 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байгаа. Машин механизмын хувьд нэг том эксковатор, таван ачааны машинтайгаар өвөл хуралдаж, хөлдсөн мөсийг зөөж зайлуулан шар ус хүлээж авах бэлтгэл ажлыг хийж байна. Нэг зүйлийг хэлэхэд, иргэд зарим зүйл дээр буруу ойлголттой байна. Айлын доороос ус олгойдож гарч ирсэн гэж яриад байх юм. Энэ чинь цаанаас орж ирсэн голын голдиролыг хааснаас болсон. Өөрөөр хэлбэл, байгалийн өөрийнх нь тогтоцыг өөрчилж шороо асган бууж, иргэд өөрсдөдөө аюул үүсгэсэнтэй холбоотой. Хөлдсөн мөсөн доогуур ус урсаж байгаа шүү дээ. Тэр ус аль дулаан газраас өөрөө гарч ирдэг. Түүнээс л болсон. Гэтэл энд суурьшсан иргэд зөвшөөрөлтэй, зөвшөөрөлгүй гээд бие бие рүүгээ буруугаа чихдэг. Ерөөсөө л булгийн эхэнд шороо асгаж буусантай холбоотой” гэв. Хэрэг болсноос хойш холбогдох байгууллагаас шороон далан ухаж, усны урсацыг Ботаникийн цэцэрлэгт хүрээлэн рүү чиглүүлсэн хэдий ч зарим иргэд өөрсдийн амин хувиа бодож ухсан шуудуун дээр шороо асгаж, голд нь тасалдуулсан гэнэ. Түүнээс болж усны урсац зогсож, их хэмжээний ус тогтох нэг шалтгаан болжээ. Ийнхүү ярилцсаны дараа бид анх булгийн ус ундран гарсан айлын хашааг зорин алхлаа.



### Улаанбаатарт амьдрал байвч газар алга

Цааш алхах тусам ямар нэгэн өрөмдлөгийн машины чимээ тодорч, хажуугаар том том мөс ачсан ачааны машин дайвалзан өнгөрнө. Энэ нь булгийн ус гарч ирсэн айлын хашаа ойртож буйн илрэл аж. Бид машин багтахуйц хэмжээтэй гудамжаар баруун зүүн эргэн сүлжин явсаар мөс ачиж буй эксковатор машины араас яваад орчихлоо. Эксковаторын урдхан талд өндөр шороон далан босгосон харагдах бөгөөд хойд талд нь цэлийсэн мөсөн дунд хэвлэл мэдээллийн хэрэгслээр нэг хэсэг гарсан байшин, хоёр машин мөнөөх л хэвээрээ дүнсийн харагдав. Байшингийнх нь цонхнууд хагарч, хашааны банзнаас 50 см гаруй нь л энд айл амьдарч байсан гэдгийг илтгэн цухуйна. Түүнээс доош бүгд усанд автаж, хөлджээ. Булгийн устай барьцалдаж хөлдсөн байшин, машинаас цааш хөлдсөн ус цэлийн харагдана. Нэг үгээр хэлбэл, том нууран дунд айлууд ороод барьцалдаад хөлдчихсөн юм шиг байх аж. Харин том шороон далангийн урд талд байрлах хашаан дотор амьдрал хэвийн үргэлжилж, гэрийн эзэд нь хашаандаа амар амгалан юм хийж байв. Тэд нэг л өдөр огцом дулаарвал түрэн орж ирэх их усанд хамгийн түрүүнд өртөх боловч тэгж бодож байгаа ч юм алга. Биднийг булгийн усанд автсан айлын хажууд зогсож байх хооронд мөс ачсан хоёр том ачааны машин ойролцоох голыг зорин одов. Эксковаторын том шанага хатуу мөсийг зовох юмгүй цөмлөн, хэдэн хэсэг бутлан машинд ачиж байгааг харвал ойрын хэдэн өдөртөө багтаад энэ хавийн мөсийг цэвэрлэчихээр санагдав. Энд манай сурвалжлах хэсэг оршин суугчидтай уулзаж, ярилцсан. Бидэнтэй хамгийн түрүүнд уулзсан хүн бол тус хэсэгт 20 орчим жил амьдарсан гэх н.Сумъяабазар гуай юм. Тэрбээр “Манайх энд амьдраад олон жил болж байна. Өмнө нь энэ газар битүү зүлэг, ногоо, цэцэгтэй байсан. Урьд жилүүдэд ийм зүйл огт болдоггүй байлаа. Миний бодлоор баруун, зүүн талаар хоёр шуудуу гаргаж, дээд булгийн усаар Ботаникийн цэцэрлэгийг усалдаг юм. Шуудуугаар нь жараахайтай цэнгэг ус урсдаг. Гэхдээ Амгалан дулааны станцыг барихдаа баруун талын шуудууг нь хаачихсан юм билээ. Түүнээс болж урсац нь хаагдаж, энэ хавь руу ус оргилон гарч ирсэн. Манай энэ хавиар бас зөвшөөрөлгүй айлууд ирж, шороо асган буусан. Түүнээс л боллоо. Бидний амьдрал хэцүү байна шүү дээ. Хөдөө, орон нутгаас ирсэн хүмүүс хотод суурьших гээд л хаа таарсан газраа буучихдаг. Зарим айлууд нь газрын зөвшөөрөлтэй. Бид нэгэнт энд суурьшаад олон жил болчихлоо. Одоо эндээс нүүхэд хэцүү байна. Нүүгээд хаашаа ч очих юм билээ. Нийслэлээс хүн ирээд биднийг гурав хоногийн дотор хурдан нүү гэсэн бичиг өгсөн. Би нүүхгүй ээ. Хаашаа нүүх юм, өвлийн хүйтэнд. Төрийн албаны хүн гэхэд их дээрэлхүү зантай хүмүүс ирээд явсан” хэмээн бидэнд хуучлав. Одоогийн байдлаар тус хэсэгт дүүргийн Засаг даргын зөвшөөрөлтэй 45 айл, зөвшөөрөлгүй 30 гаруй айл байдаг гэнэ. Уг нь Нийслэлийн хот төлөвлөлтийн газраас энэ хэсэгт ногоон байгууламж барихаар төлөвлөсөн хэдий ч айлууд нь газраа чөлөөлж өгөөгүй эдүгээг хүрчээ. Бидэнтэй таарсан дараагийн оршин суугч бол В.Эрдэнэпүрэв. Тэрбээр “Манайх газрын зөвшөөрөлтэй. Өмнө нь ийм зүйл огт болдоггүй байсан. Энэ жил л ийм болчихлоо. Энэ айл шороо асгаснаас болж ус гарч, хойноос ус урсаж орж ирээд байна. Энэ айлууд бүгд зөвшөөрөлгүй. Манайх энд 10 гаруй жил амьдарлаа. Зөвшөөрлөө дүүргээс авч байсан. Саяхан Онцгой байдлын газраас ирж далан тавьсан болохоор хавар гайгүй байх гэж бодож байгаа” гэв. Нийслэлийн онцгой байдлын газрын албан хаагчдын босгосон даланд итгэж суугаа энэ 30 орчим насны залуугийн гэр анх булгийн ус ундран гарч ирсэн хашааны зүүн хойхно байрладаг. Түүний хашаанд мөн л гараар цохих боломжгүй зузаан мөс хуралджээ. Энэ мэтчилэн Баянзүрх дүүргийн X хорооны Амгалан дулааны станцын зүүн хойно байрлах хэсгийн иргэд газрын зөвшөөрөлтэй, зөвшөөрөлгүй хэмээн хоорондоо зөрчилдөн хуваагдчихаад байгаа аж. Энэ бол нийслэлийг зорин ирэх иргэдэд газар олдоггүйн нэгээхэн жишээ. Түүнээс болж иргэд өөрийн амь биеийг ч хайхралгүй хүссэн газраа бууж байна. Гэрэлтэй, цахилгаантай, ажилтай хот хүрээ газрыг зорин ирэгсдийн цуваа жилд дунджаар 15-30 мянгаар тоологддог байна. Түүнээс одоогийн байдлаар Улаанбаатар хотод үерийн аюултай бүсэд амьдардаг 2500 гаруй өрх байдаг аж. Тэдний хэлдэг ганцхан шалтгаан нь “газар олдохгүй байна” гэх үг. Гэхдээ газар олдохгүй байна гэх шалтгаанаар өөрийн болон аав, ээж, үр хүүхдийнхээ амийг дэнчинд тавин байж зөвшөөрөлгүй, аюултай газар буух хэрэг юун.


**“НАКО ТҮЛШ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД**

“НАКО ТҮЛШ” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2017 оны 04 дүгээр сарын 21-ны Баасан гарагийн 14:00 цагт СБД, 1 хороо, Ландмарк оффисын байр, 4 давхар, “Шарын Гол” ХК-ийн хурлын өрөөнд болно.

Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийг бүртгэх өдөр: 2017 оны 03 сарын 24 өдөр

**Хэлэлцэх асуудлууд:**

- Компанийн 2016 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах
- Компанийн аудитын хорооны тайланг хэлэлцэн батлах
- 2017 оны ажлын төлөвлөгөөг хэлэлцэн батлах
- ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох
- ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагын 2017 оны зардлын төсвийг батлах
- Компанийн ногдол ашгийн талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг хэлэлцэн батлах

Хурлын материал, гарах шийдвэрийн төсөл болон холбогдох баримт бичигтэй ажлын өдрүүдэд 900-1700 цагийн хооронд Сүхбаатар дүүрэг, 2 хороо, Болор бизнес төв, 201 тоотод ирж танилцах боломжтой.

**Холбоо барих: 99469713, 99092210**
**И-мэйл: naco.dir@gmail.com**

**“ХОТ ДЕВЕЛОПМЕНТ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД**

“ХОТ ДЕВЕЛОПМЕНТ” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2017 оны 04 дүгээр сарын 21-ны Баасан гарагийн 12:00 цагт СБД, 1 хороо, Ландмарк оффисын байр, 4 давхар, “Шарын Гол” ХК-ийн хурлын өрөөнд болно.

Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийг бүртгэх өдөр: 2017 оны 03 сарын 24 өдөр

**Хэлэлцэх асуудлууд:**

- Компанийн 2016 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах
- Компанийн аудитын хорооны тайланг хэлэлцэн батлах
- 2017 оны ажлын төлөвлөгөөг хэлэлцэн батлах
- ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох
- ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагын 2017 оны зардлын төсвийг батлах
- Компанийн ногдол ашгийн талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг хэлэлцэн батлах

Хурлын материал, гарах шийдвэрийн төсөл болон холбогдох баримт бичигтэй ажлын өдрүүдэд 900-1700 цагийн хооронд Сүхбаатар дүүрэг, 2 хороо, Болор бизнес төв, 201 тоотод ирж танилцах боломжтой.

**Холбоо барих: 88009111, 99092210**
**И-мэйл: purevbaatar@gobicaravan.mn**

**“БЭРХ УУЛ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД**

“БЭРХ УУЛ” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2017 оны 04 дүгээр сарын 24-ны Даваа гарагийн 12:00 цагт Баянгол зочид буудлын хурлын танхимд болно.

Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийг бүртгэх өдөр: 2017 оны 03 сарын 24 өдөр

**Хэлэлцэх асуудлууд:**

- Компанийн 2016 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах
- Компанийн аудитын хорооны тайланг хэлэлцэн батлах
- 2017 оны ажлын төлөвлөгөөг хэлэлцэн батлах
- ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох
- ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагын 2017 оны зардлын төсвийг батлах
- Компанийн ногдол ашгийн талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг хэлэлцэн батлах

Хурлын материал, гарах шийдвэрийн төсөл болон холбогдох баримт бичигтэй ажлын өдрүүдэд 900-1700 цагийн хооронд Сүхбаатар дүүрэг, 2 хороо, Болор бизнес төв, 201 тоотод ирж танилцах боломжтой.

**Холбоо барих: 99092755, 99092210**
**И-мэйл: info@berkhuul.mn**

## ДУГААРЫН СУРВАЛЖЛАГА

# “Дэнчин” тавьж байна

### Булгийн устай “үзэлцэж” буй иргэд өөрсдөө мөнгө гаргаж, шуудуу ухуулжээ

Өнөөдөр шинэ долоо хоногийн хоёр дахь өдөр. Өглөөний 10:30 цаг өнгөрч байгаа хэдий ч Баянзүрх дүүргийн Х хорооныхон хөгшин залуугүй ажиллаж байна. Тэдний хүрзтэй нь хүрзээ, шүүртэй нь шүүрээ, хутгууртай нь хутгуураа барин дээрээс урсан ирэх усыг шүүрдэж, хутгуурдаж, хүрздэн зайлуулж байлаа. Зарим хэсэгт нь хүн явахын аргагүй мөс тогтож, зарим нь хайлснаас болж цөмөрнө. Сургуулийн багачууд үүгээр явахад тун аюултай юм. Хажуугаар нь машин өнгөрөхөд дэгдэж, дэрвэсэн багачууд хальтираад машин руу орохгүй гэх баталгаа алга. Өнгөрсөн нэгдүгээр сараас хойш энэ хавийн оршин суугчид болон холбогдох албаныхан булгийн устай “үзэлцэж” байгаа юм байна. Аргаа барсан оршин суугчид өөрсдөө мөнгө гарган шуудуу ухуулжээ. Энэ талаар тус хорооны иргэн Д.Нармандах “Өмнө нь С.Жавхлан гишүүн бидэнд тусалсан. Гэтэл С.Жавхлан гишүүнийг УИХ-аас буулгана гээд намчирхсан. Сүүлдээ гишүүн утсаа сольчихоод бидэнд олдохгүй байна. Бидэнд тусалдаг ганц хүн маань тэр хүн. Тавдугаар цахилгаан станцаа аврах гээд байгаа юм уу. Бид эрүүл тэгш газар буусан. Бид хохирч байна. Ганцхан Амгалан дулааны станцын ар талыг нь янзлаад байх юм. Машинтай ч явж болохгүй. Машинаа айлын хашаанд мөнгө өгөөд тавиулах нь холгүй л амьдарч байна. Дахиад жаахан дулаарвал ийшээ алхахад хэцүү болох нь. Шийдэлд хүрч байгаа юм уу. Онцгой байдал дуудаад ирэхгүй. 10-20 удаа дуудуулж ирдэг. Бид аргаа барсандаа мөнгө нийлүүлж, шуудуу ухуулллаа. Эхлээд айл бүр тусдаа арга хэмжээ авсан. Би л гэхэд 80 мянган төгрөгөөр 3-4 портер шороо асгуулсан нэмэр алга. Тэгэхээр нь энэ хавийн айлынхаа айлуудаас 10, 10 мянган төгрөг цуглуулаад ийм шуудуу гаргуулсан. Өвөл бүр машин тэрэг суугаад аймаар юм болсон. Мөнгөгүй хүмүүс чинь хэцүү юм байна. Шадар сайд ирэхдээ биднийг нүүлгэнэ гэж байна билээ. Гэтэл бид эрүүл тэгш, зөвшөөрөлтэй газар авсан. Би бол худалдаж авсан. Газрын бичиг бүх юмаа авсан. Сая хогны машин явахгүй гэж байна. Бид явж байхад та нар явахгүй яадаг юм гэж байгаад хогоо ачууллаа. Ийм болсон гээд хог хүртэл ачихгүй өнгөрчих санаатай” хэмээв. Мөн тус хорооны оршин суугчид болох хэсэг хүмүүс том машинаар олон удаа шороо зөөж асган газрыг нь тэгшилж байгаад хашаа барьж буущгаасан. Тэдний дунд хорооны хэсгийн ахлагч байсан хүн ч бий. Тэд бүгд зөвшөөрөлгүй гэдгийг тэрбээр онцолж байлаа. Хэсэг бүлэг хүмүүсийн буруу үйлдлээс болж зарим хүмүүс хохирчээ. Тэдний хэлсэнчлэн газрын зөвшөөрөлтэй хэсэг айлууд хууль бусаар ирж буусан айлуудын буруутай үйл ажиллагаанаас болж ажилдаа ч явж чадахгүй хүрз, хогийн шүүртэй зууралдан байгаа нь энэ аж. Бид ийнхүү ярилцсаны дараа Нийслэлийн онцгой байдлын газрыг зорилоо. Энд бид НОБГ-ын Дэд бүтэц, инженерийн байгууламж хариуцсан мэргэжилтэн Ц.Эрдэнэчимэгтэй уулзаж, зарим зүйлд хариулт авсан.

### Ц.Эрдэнэчимэг: Зөвхөн машин техникийн шатахуунд 50-60 сая төгрөг зарцуулсан

**-Өнгөрсөн нэгдүгээр сард Баянзүрх дүүргийн Х хороонд болсон нөхцөл байдалд НОБГ арга хэмжээ авч ажилласан. Ямар арга хэмжээ авч ажилласан бэ?**

-Бид өвөл булаг оргилж эхлэхэд 98 удаагийн рейсээр 1150 тонн шороо тээвэрлэж, айлыг тойруулж далан босгосон. Тэр хавийн айлуудыг усанд автахаас хамгаалсан. Мөн цагт 180 м3 ус сорох хүчин чадалтай насосоор 4500 тонн усыг сорж, суурьшилгүй бүсэд асгасан. Тухайн үед манайхаас 12 алба хаагч 24 цагийн ээлжинд тасралтгүй гарч ажилласан. Энэ мэтчилэн олон ажлыг тухайн үед хийж гүйцэтгэсэн. Нийслэлийн Онцгой комиссхоёрудаахуралдлаа. Машин техник хэрэгслийн шатахуунд 50-60 сая төгрөг зарцуулсан. Ингэж л иргэдийг авран хамгаалах арга хэмжээг авсан.

**-Урин дулаан цаг ирж буйтай холбогдуулан ямар арга хэмжээ авч байна вэ?**

-Нийслэлийн Засаг дарга бөгөөд нийслэлийн Онцгой комиссын дарга С.Батболд бүх мэргэжлийн байгууллагуудад албан даалгавар өгсөн. Хаврын дулаарал эхлэж байгаатай холбогдуулан болзошгүй шар усны үерийн аюул болон хур борооны үерийн аюулаас ард иргэдээ хамгаалахын тулд мэргэжлийн байгууллагуудад урьдчилан сэргийлэх ажлыг сайн зохион байгуулах, эвдэрч гэмтсэн далан сувгийг засч цэвэрлэх зэрэг үүрэгжүүлсэн албан даалгавар гаргасан юм. Үүний дагуу бүх мэргэжлийн байгууллагууд нь өөр өөрийн чиглэлийн ажлыг хийгээд явж байна. Манай байгууллага гэхэд үерийн аюултай бүсэд суурьшсан 2500 айлын судалгааг жил бүр шинэчилж гаргадаг. Яагаад гэвэл жилийн хугацаанд айлууд нүүх эсвэл шинээр айл нэмж суурьшсан байх магадлалтай. Тиймээс жил бүр судалгааг гаргадаг. Мөн урьдчилан сэргийлэх, сэрэмжлүүлэг мэдэгдэл хүргэдэг. Одоогоор бид мэдэгдэл хүргэж байна.

**-Баянзүрх дүүргийн Х хорооны булгийн эхэнд байрлаж байгаа айлуудад гурав хоногт нүүх мэдэгдэл хүргүүлсэн гэсэн. Цаашид улам дулаарвал үер болохгүй гэх баталгаа алга. Дахин нүүлгэх мэдэгдэл хүргүүлэх үү?**

-Манайх нүүх, суух мэдэгдэл хүргүүлдэг эрх бүхий байгууллага биш. Өөрсдөө бид энд амьдраад үхсэн ч гомдолгүй. Биднүүхгүйгээд гарынхаа үсгийг зурдаг тохиолдол олон байдаг. Бид аюул тохиолдсон үед мэргэжлийн байгууллагуудыг гаргаж арга хэмжээ авсан. Тэнд асар их шороо асгаж, шороон далан босгосон. Цаашид суурьшлын бүс биш ногоон төгөл болгох чиг баримтлан ажиллаж байгаа юм билээ. Тэгэхээр тэдгээр айлуудад холбогдох газрууд нь арга хэмжээ авах байх. Манайх бол тусалдаг, авардаг, хамгаалдаг байгууллага.

### Иргэдийн буруутай үйл ажиллагаа, төрийн буруу шийдвэрээс болж улсын мөнгө салхинд хийсч байна

Нийслэлийн Баянзүрх дүүргийн Х хороонд үүссэн нөхцөл байдалд арга хэмжээ авах машин техникийн зөвхөн шатахуунд л гэхэд 50-60 сая төгрөг зарцуулжээ. 60 сая төгрөг гэдэг маш их мөнгө. Энэ мөнгөөр нийгэмд үр ашигтай олон зүйлийг хийж болно. Гэвч газартай л болж байвал хаана ч байсан яах вэ гэх аминчхан үзэлтэй иргэдийн буруутай үйл ажиллагаа, нөгөөтэйгүүр өдрөөс өдөрт тэлж буй нийслэл хотынхоо газар зохион байгуулалтыг төлөвлөж, дорвитой шийдвэр гаргаж чадахгүй байгаа төрийн томчуудаас болж улсын мөнгө зүгээр л салхинд хийсч байна гээд хэлчихвэл нэг их хатуудахгүй биз. Иргэд нь ухамсартай, төр засаг нь зөв бодлоготой байсан бол ийм их хор хохирол учрахгүй байсан биз ээ. Ногоон төгөл байгуулахаар төлөвлөж байсан намаг балчиг ихтэй газарт дур мэдэн зөвшөөрөл олгож, тэнд амиараа дэнчин тавьж буй иргэд ч хүнд байдалд орохгүй байсан нь лавтай. Үнэндээ алга дарам газрын төлөө амиараа дэнчин тавьж буй хүмүүст хандаж хэлэхэд олны хэлж заншсанаар орк зангаа татаж, амин хувиа хичээхээ больж, их хотын соёлд суралцахыг сануулмаар байна. Нэг хүний, хэсэг бүлгийн эрх ашгаар нийтийн эрх ашиг хязгаарлагдах ёс үгүй.












## ТЕНДЕРИЙН УРИЛГА

**Огноо:** 2017 оны 03 дугаар сарын 22
**Тендер шалгаруулалтын нэр:** Үндэсний батлан хамгаалахын их сургууль, Цэргийн төв эмнэлгийн хэрэгцээт хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэх
**Тендер шалгаруулалтын дугаар:** БХЯ/201700001

Батлан хамгаалах аж үйлдвэрийн нэгдэл ТӨААТҮГ эрх бүхий тендерт оролцогчдоос хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдлээр нь 50,000 төгрөг, эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний чөлөөтэй хөрвөх валютаар худалдан авч болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн [45] хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

**Үүнд:**

**Борлуулалтын хэмжээ:** Багц тус бүрийн хувьд санал болгож байгаа үнийн дүнгийн 100%-ийн үнийн дүнтэй тэнцүү хэмжээний борлуулалтын орлоготой байх.

**Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ:** Багц тус бүрийн хувьд санал болгож байгаа үнийн дүнгийн 100%-ийн үнийн дүнтэй тэнцүү хэмжээний түргэн хөрвөх чадвартай хөрөнгөтэй байх.

Тендерийн хамт 1-р багцад 739 500 төгрөг, 2-р багцад 402 150 төгрөгийн тус тус дүнтэй банкны баталгаа ирүүлнэ.

Тендерийг 2017 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 10.00 цагаас өмнө доорх хаягаар ирүүлэх ба тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2017 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 10.30 цагт Батлан хамгаалах аж үйлдвэрийн нэгдэл ТӨААТҮГ-ын байрны 1 давхрын Хурлын танхимд нээнэ.

**Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхгүй.**
**Дотоодын давуу эрх тооцно.**

*Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно. Тендерийн баримт бичиг худалдан авах үнийг БХАҮН ТӨААТҮГ-ын Хаан банкин дахь 50 99 98 00 55 тоот дансанд тушаана.*

**Баянзүрх дүүрэг, Дандарбаатарын гудамж, 16 дугаар хороо, Засгийн газрын 7 дугаар байрны дэргэд Батлан хамгаалах аж үйлдвэрийн нэгдэл ТӨААТҮГ-ын байрны 2 давхрын 2 тоот өрөө. Утас: 95584084, Г. Хандмаа**

## ТЕНДЕРИЙН УРИЛГА

**Огноо:** 2017оны 03 дугаар сарын 22
**Тендер шалгаруулалтын нэр:** Үндэсний батлан хамгаалахын их сургууль, Цэргийн төв эмнэлгийн хэрэгцээт шатахуун нийлүүлэх
**Тендер шалгаруулалтын дугаар:** БХЯ/201700003

Батлан хамгаалах аж үйлдвэрийн нэгдэл ТӨААТҮГ эрх бүхий тендерт оролцогчдоос хувцас хэрэглэл нийлүүлэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдлээр нь 50,000 төгрөг, эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний чөлөөтэй хөрвөх валютаар худалдан авч болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн [45] хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

**Үүнд:**

**Борлуулалтын хэмжээ:** Багц тус бүрийн хувьд санал болгож байгаа үнийн дүнгийн 100%-ийн үнийн дүнтэй тэнцүү хэмжээний борлуулалтын орлоготой байх.

**Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ:** Багц тус бүрийн хувьд санал болгож байгаа үнийн дүнгийн 100%-ийн үнийн дүнтэй тэнцүү хэмжээний түргэн хөрвөх чадвартай хөрөнгөтэй байх.

Тендерийн хамт 1-р багцад 982. 991 төгрөг, 2-р багцад 2. 255. 625 төгрөгийн тус тус дүнтэй банкны баталгаа ирүүлнэ.

Тендерийг 2017 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн 10.00 цагаас өмнө доорх хаягаар ирүүлэх ба тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2017 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн 10.30 цагт Батлан хамгаалах аж үйлдвэрийн нэгдэл ТӨААТҮГ-ын байрны 1 давхрын хурлын танхимд нээнэ.

**Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй.**

*Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно. Тендерийн баримт бичиг худалдан авах үнийг БХАҮН ТӨААТҮГ-ын Хаан банкин дахь 50 99 98 00 55 тоот дансанд тушаана.*

**Баянзүрх дүүрэг, Дандарбаатарын гудамж, 16 дугаар хороо, Засгийн газрын 7 дугаар байрны дэргэд Батлан хамгаалах аж үйлдвэрийн нэгдэл ТӨААТҮГ-ын байрны 2 давхрын 2 тоот өрөө. Утас: 95584084, Г.Хандмаа**

## ТЕНДЕРИЙН УРИЛГА

**Огноо:** 2017оны 03 дугаар сарын 22
**Тендер шалгаруулалтын нэр:** Үндэсний батлан хамгаалахын их сургууль, Цэргийн төв эмнэлгийн хэрэгцээт эм, ороох боох материал нийлүүлэх
**Тендер шалгаруулалтын дугаар:** БХЯ/201700004

Батлан хамгаалах аж үйлдвэрийн нэгдэл ТӨААТҮГ эрх бүхий тендерт оролцогчдоос эм, ороох боох материал нийлүүлэх тухай битүүмжилсэн тендер ирүүлэхийг урьж байна.

Тендерийн баримт бичгийг (хүсвэл нэмэлт хувийг) бичгээр хүсэлтээ гаргаж, эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдлээр нь 50,000 төгрөг, эсхүл түүнтэй тэнцэх хэмжээний чөлөөтэй хөрвөх валютаар худалдан авч болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн [45] хоногийн дотор хүчинтэй байна.

Тендерт оролцогч нь Санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна.

**Үүнд:**

**Борлуулалтын хэмжээ:** Багц тус бүрийн хувьд санал болгож байгаа үнийн дүнгийн 100%-ийн үнийн дүнтэй тэнцүү хэмжээний борлуулалтын орлоготой байх.

**Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ:** Багц тус бүрийн хувьд санал болгож байгаа үнийн дүнгийн 100%-ийн үнийн дүнтэй тэнцүү хэмжээний түргэн хөрвөх чадвартай хөрөнгөтэй байх.

**Тендерийн хамт :** 1-р багцад 181,878.00 төгрөг, 2-р багцад 10,295.00 төгрөг, 3-р багцад 672,042.00 төгрөг, 4-р багцад 735,743.25 төгрөг, 5-р багцад 367,419.00 төгрөг, 6-р багцад 33,000.00 төгрөг, 7-р багцад 69,588.00 төгрөг, 8-р багцад 229,065.00 төгрөг, 9-р багцад 2,162,775.60 төгрөг, 10-р багцад 472,500.00 төгрөг, 11-р багцад 157,500.00 төгрөг, 12-р багцад 20,850.00 төгрөг, 13-р багцад 61,836.00 төгрөг, 14-р багцад 89,280.00, 15-р багцад 22,500.00 төгрөг, 16-р багцад 8,775.00 төгрөг, 17-р багцад 11,478.00 төгрөг, 18-р багцад 44,232.00 төгрөг, 19-р багцад 39,300.00 төгрөгний мөнгөн дүн бүхий банкны баталгаа тус тус ирүүлнэ.

Тендерийг 2017 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 13.00 цагаас өмнө доорх хаягаар ирүүлэх ба тендерт оролцогчдыг байлцуулан тендерийг 2017 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 13.30 цагт Батлан хамгаалах аж үйлдвэрийн нэгдэл ТӨААТҮГ-ын байрны 1 давхрын хурлын танхимд нээнэ.

**Гадаадын этгээд тендер ирүүлэх эрхтэй.**
**Дотоодын давуу эрх тооцно.**

*Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно. Тендерийн баримт бичиг худалдан авах үнийг БХАҮН ТӨААТҮГ-ын Хаан банкин дахь 50 99 98 00 55 тоот дансанд тушаана.*

**Баянзүрх дүүрэг, Дандарбаатарын гудамж, 16 дугаар хороо, Засгийн газрын 7 дугаар байрны дэргэд Батлан хамгаалах аж үйлдвэрийн нэгдэл ТӨААТҮГ-ын байрны 2 давхрын 2 тоот өрөө. Утас: 95584084, Г.Хандмаа**

NO STRESS

УРАН БҮТЭЭЛЧ

Ж.ОТГОН

*Дэлхий дахинд 2017 оны Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийн сарыг “Be Bold for Change” буюу “Өөрчлөлтийн төлөө зоригтой бай” уриан дор тэмдэглэж байна. Энэ хүрээнд “Өөрчлөлтийн төлөөх эмэгтэйчүүд” ТББ нь “IC Creative Division” студитэй хамтран АНУ-ын ЭСЯ-ны дэмжлэгээр “Сайхан бие 2.0” гэрэл зургийн үзэсгэлэнг UB Art Gallery-д нээгээд байгаа. Тус үзэсгэлэнгээр дамжуулан гоо сайхан бол тогтсон, хэвшмэл ойлголт биш болохыг харуулахыг зорьжээ. Энэхүү үзэсгэлэнгийн талаар “Өөрчлөлтийн төлөөх эмэгтэйчүүд” ТББ-ын захирал Д.Золзаятай ярилцлаа.*



*Гэрэл зургийг Г.АРГУУЖИН*



# Д.Золзаяа: Бүсгүйчүүд таргалалтаас айж, эрүүл бус сонголтуудыг хийж байна

**-“Сайхан бие 2.0” гэрэл зургийн үзэсгэлэнг яагаад гаргах болов. Гоо сайхан гэх тогтсон, хэвшмэл ойлголтыг яагаад эвдэхийг хүссэн юм бол?**

-Энэхүү үзэсгэлэн маань хоёр дахь удаагаа гарч байгаа. Өмнө нь 2014 онд гарч байлаа. Энэ удаагийн үзэсгэлэнг гаргах ямар шаардлага хэрэгцээ байсан гэхээр 800 гаруй эмэгтэйчүүдээс судалгаа авахад 90-95 хувь буюу дийлэнх нь биедээ сэтгэл хангалуун бус байдаг гэсэн хариулт өгсөн. Өөрөөр хэлбэл, өөрийнхөө биеийн аль нэг хэсэгт тааламжгүйханддаг гэсэн үг. Гэтэл ийнхүү өөртөө сэтгэл хангалуун бус байдаг байдалд нь хувийн амьдрал болоод ажил мэргэжил, карьерынх нь бүх нөхцөл байдалд нь нөлөөлж байдаг. Уг асуудал зөвхөн Монголд биш. Эмэгтэй хүн өөрийнхөө гадаад байдалд сэтгэл хангалуун бус байдаг байдал нь дэлхий дахинд байдаг асуудал.

**-Эмэгтэйчүүдийн гадаад байдалд сэтгэл хангалуун бус байх байдал нь юунаас болоод байгаа гэж харж байна?**

-Энэ юутай холбоотой вэ гэхээр ихэнхдээ өөрт байгаа онцлог байдлаа таашааж, түүнийгээ гэрэлтүүлж чадахгүй байгаатай холбоотой. Түүний оронд ямар нэгэн өөр зүйлтэй өөрийгөө харьцуулаад байдагт учир нь байгаа юм. Тухайлбал, ихэнх бүсгүйчүүд сэтгүүлийн нүүрэнд гарсан фото модел, загвар өмсөгч, дуучин, жүжигчинтэй өөрийгөө харьцуулаад байдаг. Загвар өмсөгч хүн гэдэг бол өөрийн гэсэн онцлогтой, ажил мэргэжилтэй түүнийхээ төлөө зогсолтгүй хөдөлмөрлөж байдаг хүмүүсийн төлөөлөл байгаа. Гэтэл огт өөр ажил, мэргэжилтэй, тэс өөр биеийн хэлбэр хэмжээтэй эмэгтэйчүүд тэр хүн шиг болох гэснээрээ маш их цаг хугацаа, мөнгө, бие сэтгэлээрээ хохирч байдаг. Үүнээс маш олон бүсгүйчүүд эрүүл мэндээрээ хохирсоор байна. Тухайлбал, биедээ хортой хоолны дэглэм барих, удаан хугацаанд юм идэхгүй явах, өндөр үнэтэй тураах бэлдмэл уух зэрэг нь эмэгтэйчүүдийн гадаад байдалд эерэг гэхээсээ сөрөг байдлаар нөлөөлж байдаг. Тиймээс манай үзэсгэлэнгийн зорилго “Бид бүгд энэ биеэрээ хорвоод ирсэн гэдэг бол энэ л бие цогцосдоо сэтгэл хангалуун аз жаргалтайгаар өөрийнхөө түүхийг бүтээх учиртай юм” гэсэн санааг илэрхийлж буй. Өөрт байгаа гоо үзэсгэлэнгээ мэдэрсэнээр түүнийгээ гэрэлтүүлэх хэрэгтэй. Биеийнхээ аль хэсэг нь сайхан юм, гоё юм түүнийгээ гэрэлтүүлдэг байх ёстой гэсэн үг. Гэтэл бүсгүйчүүд маань одоо өглөө босоод толинд харахдаа “хамраа өндөрлүүлэх юмсан, нүдэндээ давхраа хийлгэхсэн” гэж боддог, хардаг. Магадгүй бүсгүйчүүд маань ингэж боддог, хардаг болоход нөлөөлж байгаа хамгийн том хөшүүрэг нь зар сурталчилгаанууд байж болох юм. Тухайлбал, ямар нэгэн гоо сайханы брэнд бүтээгдэхүүнүүд “Та үүнийг ав, түүнийг ид, үүнийг хэрэглээд энэ бүсгүй шиг болно” гээд эмэгтэйчүүдэд нөгөө хийсвэр дүр төрхийг тулгаж байдаг. Хийсвэр гэсний учир нь зар сурталчилгаанд тоглож байгаа загвар өмсөгч нь ч өөрөө түүнтэйгээ адилхан байхад хэцүү шүү дээ. Тухайн зургийг нь маш их хэмжээгээр янзалж байж зар сурталчилгааны зургийг бүтээдэг. Гэхдээ сурталчилгаагаа хийхдээ “Энэ бүтээгдэхүүнийг аваад хэрэглэчихвэл энэ бүсгүй шиг болно” гээд байдаг. Тиймээс энэ бүхнийг бодож, тунгаагаад өөртөө байгаа гоо сайхнаа гэрэлтүүлээрэй гэдгийг бүсгүйчүүддээ хэлэхийг хүсч байгаа юм.

**-Өмнө нь 2014 онд гаргаж байсан үзэсгэлэн мөн ийм сэдэвтэй байсан юм уу?**

-Тухайн үед гарч байсан үзэсгэлэнд бүсгүйчүүд өөрийнхөөрөө л зургаа даруулсан. Харин энэ удаад дэлхийн шилдэг 22 уран зургийн бүтээлийг сонгож аваад, түүнийгээ орчин үеийн хэлбэрт оруулсан. Эдгээр бүтээлүүдийг сонгож авах болсон бэ гэхээр тухайн үеийн зураачид, уран бүтээлчид өөртөө сайхан гэж харагдаж байгаа, үзэгдэж байгаа мэдрэмжүүдээ өөрийнхөөрөө илэрхийлж чадсан. Үүнээс үзэхэд бүсгүйчүүдийн гоо үзэсгэлэн гэдэг бол тогтсон хэвшмэл ойлголт болох 90х60х90 гэдэг биш юм гэдгийг ойлгох болно. Энд дэлгэгдсэн бүх бүтээлүүдийг эзэд бүсгүйчүүдийн гоо сайхныг өөр өөр нүдээр харж, байдаг юм шүү гэдгийг илэрхийлж чадсан.

**-Үзэсгэлэнгийн зураг дахь моделуудаа яаж сонгов. Ихэнх нь нүцгэн байна. Мэдээж эдгээр бүсгүйчүүдээс нэлээд зориг шаардсан байх?**

-Тийм ээ. Нүцгэн зургаа олон нийтэд дэлгэнэ гэдэг амаргүй байх нь ойлгомжтой. Бидний хувьд бүсгүйчүүддээ байнга сургалт явуулдаг. Өөрийнхөө биед сэтгэл хангалуун байх, биеийн гадаад төрх зэрэг цуврал сургалтуудыг явуулдаг юм. Тиймээс сургалтынхаа явцад бүсгүйчүүдтэйгээ ярилцдаг. Яагаад бид биедээ сэтгэл хангалуун байх нь чухал юм. Сэтгэл хангалуун байх нь миний амьдралд хэрхэн нөлөөлдөг гэдгийг мэддэг. Судалгаагаар бүсгүйчүүд гадаад биедээ сэтгэл хангалуун бус үедээ ажлын амжилт үзүүлэлт нь өндөр хувиар буурдаг гэдгийг тогтоочихсон. Тухайлбал, олон хүний өмнө нэг илтгэл тавих байлаа гэхэд илтгэлтэйгээ холбоотой зүйл бодохгүй “Би ямар харагдаж байгаа бол. Тэр хэсэг маань ингэж харагдаж байгаа болов уу” гэх зэргээр шал өөр зүйл боддог. Түүнчлэн их олон цагийг хэн нэгэн шиг болохын тулд зарцуулж, хөгжих боломжоосоо хумсалж байдаг зэргийг бүсгүйчүүдтэйгээ ярилцаж, тэд маань энэхүү энгийн агуулгыг ойлгож, мэдэрдэг. Энэ бүхний үр дүнд бусад бүсгүйчүүдэд ч үүнийг ойлгуулах нь зөв юм байна гэдэг үүднээс энэхүү зоригтой алхмыг хийж, зургаа даруулсан. Түүнээс гудамжинд явж байгаа хэн нэгнийг шууд хөтөлж ирээд л зургийг нь авна гэж байхгүй. Сүүлийн үед өсвөр насны охидын дунд хоолоо идчихээд буцаагаад бөөлжиж гаргах өвчин ч гарч эхлээд байгаа. Учир нь таргалалтаас бүгд айж байна. Тиймээс ч эрүүл бус сонголтуудыг хийж байгаа юм.

**-Бүсгүйчүүдийг сургалтад хамруулдаг гэлээ. Магадгүй бүсгүйчүүд маань бидний ярилцлагыг уншаад танай сургалтад хамрагдахыг хүсэх байх?**

-“Өөрчлөлтийн төлөөх эмэгтэйчүүд” ТББ сургалт зохион байгуулдаг. Манайх ням гараг бүрт үйл ажиллагаагаа явуулдаг. Үйл ажиллагааны тухайд гэвэл тухай бүрт нь манай фэйсбүүк хуудсанд зарлагддаг. Тиймээс хүссэн бүсгүйчүүд маань манай нээлттэй үйл ажиллагаанд ирж, оролцоод явж болно. Үүнээс гадна жендэрийн тэгш эрхийн төлөө үйл ажиллагаан дотор гэхэд “Жендэрт суурилсан хүчирхийлэл”, “Эмэгтэйчүүдийн манлайллын хөтөлбөр” зэргээр олон сонирхолтой сургалтууд, ярилцлагууд явагддаг. Түүнчлэн “Залуусын хөгжлийг дэмжих буюу ардчиллын боловсролыг түгээх” хөтөлбөр гээд олон төрлийн үйл ажиллагаа байгаа. Тэр бүгд нээлттэй болдог.

**-Энэхүү үзэсгэлэнгийн дараа хийхээр төлөвлөж байгаа ямар ажил байгаа вэ?**

-Ойрын үед гэр бүлийн хүчирхийллийн эсрэг хуулийг түгээх чиглэлээр ажиллах төлөвлөгөөтэй байгаа. Хууль батлуулахыг нийгмээрээ шаардсан. Тэгвэл уг хууль иргэн бидний оролцоо ямар байх, бидний эрхийг хэрхэн хамгаалж байгаа юм гэдгийг хүмүүст таниулах болно. Түүнчлэн ажлын байрны бэлгийн дарамтын талаар, нөхөн үржихүйн болон бэлгийн эрүүл мэндийн асуудлаар мэдээлэл түгээх гээд олон ажил хүлээж байгаа. Бэлгийн боловсролын тухайд гэхэд л хүмүүс хоорондоо, эцэг, эх нь хүүхэдтэйгээ тэр бүр ярьиад байдаггүй. Ийм байхад ерөнхий боловсролын хичээлийг нь хасаад хаячихсан байх жишээтэй. Өөрөөр хэлбэл, хими, физикийн хичээлийн цагийг нэмээд эрүүл мэндийн хичээлийг хасчихсан. Гэтэл биеийн тамирын багш хүүхдүүдтэйгээ бэлгийн боловсрол яриад зогсохгүй нь ойлгомжтой. Тэгээд ч хүн бүр эрдэмтэн болохгүй. Харин хүн бүр бэлгийн харилцаанд ордог шүү дээ. Ийнхүү эрүүл мэндийн болон бэлгийн боловсролгүй хүн гэхээр бид ирээдүйд ямар иргэн бэлтгэж байна гэдэг нь өөрөө асуудал болоод байгаа. Тиймээс эрүүл мэндийн хичээлийг орхигдуулж огт болохгүй. Бид ч энэ чиглэлээр ажиллахаар төлөвлөөд байна.

Улаанбаатарт:

Маргааш

Өдөр 1
Шөнө -8

Нөгөөдөр

Өдөр 1
Шөнө -10

## Өдрийн зурхай

**ХАВРЫН ТЭРГҮҮН ХАР БАР САР ХОЁР ХАР МЭНГЭТЭЙ ШАР БИЧ ӨДӨР**

**Наран ургах шингэх:** 06.51-19.07
**Үс засуулбал:** Өвчин эмгэг ирнэ



*Тухайн өдөр гахай, хулгана, үхэр, луу, нохой жилтнээ аливаа үйлийг хийхэд зерэг сайн ба могой, морь жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Баяр баясгалангийн хурим үйлдэх, шинэ гэр барих, хувцас өмсөх, чимэг зүүх, бүжиг наадам үүсгэх, эм найруулах, гэргий авах, үс авах, элч зарах, эд авахад сайн. Зүүн нүд татвал хэрүүл, тэмцэл болох, баруун нь бол эд хувцас олох, зүүн чих нь цангинавал зочин ирэх, баруун нь бол гаслан болох, нохой уливал галзуурах, хэрээ гуаглавал ураг садан эндэх, тагнай загатнавал хэн нэгний үхсэнийг сонсох, бие татвал гэнэт зочин ирэх, хөл татвал үхэл болохыг үзэх болой. Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, луу, могой, хонь, нохой болой.*

## Бидэнд тохиолдсон ХҮНДХЭН ХӨГТЭЙ ЯВДЛУУД

Bolorerdene Amarsaikhan

10 жилээ төгсөөд арван хэдэн жилийн нүүрийг үзэж байгаа гээд ангийнхан маань уулзаж зун нэг агаар салхинд гарч баавгайн чих, дээс, тэвэг, хөлбөмбөгийн тэмцээн зохиогоод л хуучны дурсамжаа хөндсөн хоёр сайхан өдрийг өнгөрүүлсэн юм. Тэнд манай ангийн нэг залуу хундаганы үг хэлж байгаа нь:

- За ингээд энэ ангиас нэг ширээний охинтойгоо хоёулаа ирсэн хүн гэвэл би л ганцаараа байна гээд яриагаа эхэлж байтал нөгөө охин нь:

- Одоо охин мохин байхдаа яах вэ дээ гээд амихандаа чадчихлаа гэж бодоод л тас тас инээсэн чинь нөгөөх нь:

- За тэгвэл ширээний хүүхэнтэйгээ ирсэн ганц хүн нь би юм байна...


olloo

**“ОЛЛОО” ХУВЬЦААТ КОМПАНИЙ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИДИЙН АНХААРАЛД**

“Оллоо” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал
2017 оны 04-р сарын 29-ний өдрийн 14.00 цагт
Компанийн байранд болно.

Бүртгэх өдөр 2017 оны 04-р сарын 07-ны өдөр
Хувьцаа эзэмшигчид та бүхэн 2017 оны 04-р сарын 10-оос компани дээр ирж хурлын материалтай танилцана уу.

**Хурлаар хэлэлцэх асуудал:**

1. Компаний 2016 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгсөн ТУЗ-ийн дүгнэлт
2. Компаний 2017 оны ажлын төлөвлөгөө
3. ТУЗ-ийн гишүүдийг өөрчлөн томилох асуудал

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ
Лавлах утас: 772-01100


